**Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-020772 дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

ГАРЧИГ


**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ** ..... **2**
**ХАМРАХ ХҮРЭЭ** ..... **3**
**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ..... **8**
Ордын товч танилцуулга ..... 8
Орд ашиглалтын технологи ..... 9
Дэд бүтэц ..... 9
Унд ахуйн хэрэглээний ус ашиглалт ..... 9
**ХОЁР. АШИГЛАЛТЫН ТАЛБАЙ ОРЧМЫН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ** ..... **11**
Талбайн газарзүйн байршил ..... 11
Цаг уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд ..... 12
Хөрсөн бүрхэвч ..... 12
Ургамлан нөмрөг ..... 12
Амьтны аймаг ..... 12
Усан орчны төлөв байдал ..... 13
**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ** ..... **14**
*3.1.* Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөлөл ..... 14
*3.2.* Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл ..... 14
*3.3.* Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл ..... 14
*3.4.* Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл ..... 14
*3.5.* Газрын гадарга болон гүний усанд учруулах сөрөг нөлөөлөл ..... 15
*3.6.* Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал орчны эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх ..... 16
*3.7.* Нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөлөл ..... 16
**ДӨРӨВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ** ..... **17**
**“Хөөтийн хонхор-2” уурхайн 2023, 2024 онуудад хийсэн ус, хөрс, агаарын шинжилгээний үр дүн** ..... **19**
**2023 онд Байгаль орчин судалгаа, шинжилгээний төвөөс хийсэн байгаль орчны бохирдлын судалгааны үр дүн** ..... **19**
2024 оны ОХШХ-ийн хүрээнд авсан сорьцын шинжилгээний үр дүн ..... 21
1. Хөрсний шинжилгээний үр дүн ..... 21
Дүгнэлт ..... 25
2. Усны шинжилгээний үр дүн. ..... 25
Дүгнэлт. ..... 28
3. Агаарын чанарын шинжилгээний үр дүн. ..... 29
Дүгнэлт: ..... 30
**2024 онд төслийн үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж** ..... **30**
**2025 оны БОМТ-ний нийт зардал** ..... **31**
*4.1.* Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил ..... 32
*4.2.* Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил ..... 41
*4.3.* Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ..... 42
*4.4.* “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажил ..... 43
*4.5.* Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө ..... 45
*4.6.* Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө ..... 45
*4.7.* Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө ..... 45
*4.8.* Хог хаягдлын менежмент ..... 48
*4.9.* Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ..... 50
**ТАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР** ..... **52**
**ЗУРГАА. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ** ..... **56**

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл ........ 8
Хүснэгт 2. Уурхайн 2024 оны Уулын ажлын төлөвлөгөөнд тооцсон ажиллах горим ........ 8
Хүснэгт 3. Ашиглалтын технологийн схем ........ 9
Хүснэгт 4. 2024 онд унд ахуйн хэрэглээнд ашигласан усны тооцоо ........ 9
Хүснэгт 5.Ногоон байгууламжын усалгаанд ашигласан усны  хэрэглээ ........ 10
Хүснэгт 6. Гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүд ........ 13
Хүснэгт 7. Үүсэх хог хаягдлын төрөл ........ 16
Хүснэгт 8. Орон нутгаас өгсөн  санал ........ 17
Хүснэгт 9. Дээж авсан цэгийн байршил ........ 19
Хүснэгт 10. Дээж авсан цэгийн байршил ........ 22
Хүснэгт 11. Хөрсний химийн шинж чанар. ........ 23
Хүснэгт 12. Хүнд металлын шинжилгээ ........ 24
Хүснэгт 13. Хөрсний механик бүрэлдэхүүн. ........ 25
Хүснэгт 14. Усны шинжилгээний үр дүн ........ 26
Хүснэгт 15. Дээж авсан цэгийн байршил ........ 27
Хүснэгт 16. Усны шинжилгээний үр дүн ........ 27
Хүснэгт 17. Цооногийн хэмжилт. ........ 28
Хүснэгт 18. Агаарын чанарын шинжилгээний үр дүн ........ 30
Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал ........ 31
Хүснэгт 20. Хяналтын цэг байгуулах цэгийн солбицол (дээж авах цэгийн байршил сонгохдоо төслийн талбайд 2023, 2024 онуудад хийсэн мониторингийн судалгаанд үндэслэв.) ........ 52

# Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-020772 дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

## ОРШИЛ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-020772 дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн 2025 оны БОМТөлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хянах батлах, тайлагнах журам”-ыг үндэслэн, төслийн 2024.06.06-нд батлагдсан БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлан болон 2025 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулж, тус төслийн 2024 онд хэрэгжүүлсэн БОМТөлөвлөгөөний биелэлтийг дүгнэх ажлын үед орон нутгаас өгсөн саналуудыг тусган боловсруулав.

Менежментийн төлөвлөгөө нь бүтэц агуулгын хувьд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл,
- Төслийн танилцуулга,
- Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй,
- Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт,
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө,
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэсэн хэсгээс бүрдэнэ.

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах үйлдвэр, үйлчилгээний аливаа төсөл нь байгаль орчны хуулиудаар тогтоосон хэм хэмжээ ба төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан стандарт, нормын шаардлагад нийцүүлэн хэрэгжих ёстой.

Тус төслийг төслийг хэрэгжүүлэх явцад дараах байгаль орчны хуулиуд, агаар, ус, хөрсний чанарын стандартуудыг дагаж мөрдөнө.

## ХАМРАХ ХҮРЭЭ

| **Хуулийн заалт** | **Зүйл** |
|---|---|
| **Монгол улсын үндсэн хуулиас** | |
| 1. Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.<br>2. Монгол улсад иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.<br>3. Төр газрын эзэд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлыг ашиг сонирхолд харшаар ашиглавал хурдан авч болно. | Монгол Улсын Үндсэн Хууль Зургаадугаар зүйл |
| 4. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. | Арвандолдугаар зүйл |
| **Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас** | |
| Иргэн, аж ахуйн нэгж, байгуулага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараах үүрэгтэй.<br>Хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях. | Тавдугаар бүлэг Хориннэгдүгээр зүйл Байгаль орчныг бохирдохоос хамгаалах |

| | |
|---|---|
| Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна.<br>1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;<br>2. Бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн | Гучиннэгдүгээр зүйл<br>Аж ахуйн нэгж байгууллагын үүрэг |

| | |
|---|---|
| үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх;<br>3. Өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх. | |
| **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиас** | |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.<br>Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна;<br>Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.<br>Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага батална. | Есдүгээр зүйл<br>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| **Агаарын тухай хуулиас** | |
| 9.1.1 Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах<br>9.1.2 Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох<br>9.1.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах<br>9.1.4 Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвөлгөө авах<br>9.1.5 Агаарын бохирдлыг бууруулах талаар холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх<br>9.1.6 Агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах | Есдүгээр зүйл<br>Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг |
| 17.1 Агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, түүнчлэн хөдөлгөөнт эх үүсвэрийн төрөл бүрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ,тэдгээрийг тодорхойлох аргыг стандартаар тогтооно. | Арвандолдугаар зүйл<br>Агаар хамгаалахтай хэм хэмжээ |
| 23.1 Аж ахуйн нэгж байгууллага нь ашиглалтанд орсон хугацааг харгалзахгүйгээр агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр нэг бүрээ хянах, агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмж багаж хэрэгслээр тоноглоно.<br>23.2 Агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах, эх үүсвэр бүрийг хяналтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглох, тэдгээрийн ашиглалтын байдалд тухайн салбарыг харьяалах, төрийн захиргааны төв байгууллага, сум дүүргийн Засаг дарга байгаль орчны байцаагч хяналт хийнэ. | Хорингуравдугаар зүйл<br>Эх үүсвэрийг тоноглох |
| **Газрын тухай хуулиас** | |
| 35.3.4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх; | 35 дугаар зүйл. Газар |

| | |
|---|---|
| 55.1. Газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.<br>55.2. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна. | эзэмшигчийн эрх, үүрэг<br><br>55 дугаар зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах |
| **Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль** | |
| Төсөл хэрэгжүүлэгч нь тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх, төслийн ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх ёстой.<br>Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох, үйл ажиллагааныхаа явцад доройтсон хөрсийг биологийн нөхөн сэргээлтийн стандартын шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээх, хөрсний ялзмаг, үржил шимийг тогтоох, доройтлоос хамгаалах зорилгоор гуу, жалга үүсэж болох газарт хаалт хамгаалалт хийх, ойжуулах ёстой. | 7 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ |
| **Байгалийн ургамлын тухай хуулиас** | |
| 7.1 Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. | Долдугаар зүйл Ургамлыг хамгаалах |
| **Галын аюулгүй байдлын тухай хуулиас** | |
| 1. Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймэрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна. | Арван наймдугаар зүйл<br>Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих нийтлэг шаардлага |
| **Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам** | |
| 1. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэр, ахуйн бохир усаа ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх боломжгүй тохиолдолд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүйгээр урьдчилан цэвэрлэж,халдваргүйжүүлэн, бэлтгэсэн цэг талбайд байрлуулна.<br>2. Хаягдал ус зайлуулах цэгийг байгаль орчин, эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын шийдвэрээр тогтооно.<br>3. Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журмыг зөрчвөл “Байгаль хамгаалах тухай” болон “Усны тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. | Нэг<br>Нийтлэг үндэслэл |
| | |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль** | |
| Төсөл хэрэгжүүлэгч нь уг хуульд заасны дагуу галын аюулгүй байдалд тавих шаардлагуудыг хангах болон ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулах ёстой.<br>Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгуллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцах ба үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга | 28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг |

| | |
|---|---|
| хэмжээ авах, хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ гаргуулах ёстой. | |

**Стандарт, норм, норматив**

| № | Дугаар | Нэр |
|---|---|---|
| **1** | MNS 5916:2008 | Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт Техникийн шаардлага |
| **2** | MNS 5918:2023 | Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага |
| **3** | MNS 5885:2008 | Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ |
| **4** | MNS 4585:2016 | Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага |
| **5** | MNS 5850:2019 | Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| **6** | MNS4943-2011 | Усны чанар, хаягдал бохир ус |
| **7** | MNS 3342:1982 | Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах. Ерөнхий шаардлага |
| **8** | MNS 0900:2018 | Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт |
| **9** | MNS 3298:1991 | Байгаль хамгаалал. Хөрс шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд |
| **10** | MNS ISO 226 : 2003 | Дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ |
| **11** | MNS 5342:2007 | Автомашины зогсоол, ангилал. еренхий шаардлага |
| **12** | MNS 0017-0-0-06:1979 | Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм |

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай “Биг могул коул энд энержи” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 уурхай нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ил аргаар олборлох уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | “Биг могул коул энд энержи” ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011665117 |
| Регистрийн дугаар: | 5369223 |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | MV-020772 |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Цэнтрүүм барилга, 4 давхар, 401 тоот |

Уурхай нь нийтийн баяр ёслолын өдрүүд, цаг агаарын саатал болон засвар үйлчилгээ хийх өдрүүдээс бусад үед жилийн дөрвөн улирал тасралтгүй, хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллана.

Хүснэгт 2. Уурхайн 2024 оны Уулын ажлын төлөвлөгөөнд тооцсон ажиллах горим

| № | Үзүүлэлтүүд | Утга |
|---|---|---|
| 1. | Жилийн календарчилсан хоногийн тоо | 365 |
| 2. | Уурхайн амрах хоног | 15 |
| 3. | Засвар үйлчилгээ, цаг агаарын саатал | 24 |
| 4. | Уурхайн жилд ажиллах хоног | 326 |
| 5. | Ээлжийн тоо | 2 |
| 6. | Ээлжийн үргэлжлэх хугацаа | 12 |
| 7. | Жилд ажиллах цаг | 7,824 |

**Ордын товч танилцуулга.**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020772 тоот дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй ордыг анх 2014 онд ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд 2017 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулж эхлэсэн.

Ордын 2023 онд хийгдсэн ТЭЗҮ-д тусгаснаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 12-р сарын 24-ний өдрийн XX-24-07 тоот дүгнэлтээр Хөөтийн хонхор-2 талбай дахь нийт бодитой болон боломжтой (В+С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 18,191.21 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 19,869.87 мян. тн-оор, үүнээс эдийн засгийн үр ашигтай бодитой (В) зэргийн цэвэр нөөц 7,189.31 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 7,835.32 мян. тн-оор, эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 10,750.26 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 11,899.34 мян. тн-оор баталжээ. Үүнээс 2021 оны эцсийн тайлангаар үлдэгдэл нөөцийн хэмжээ бодитой (В) зэргээр 6,874.14 мян.тн, боломжтой (С) зэргээр 10,661.11 мян.тн болсон байна.

**Орд ашиглалтын технологи.**

"Хөөтийн хонхор"-2 нүүрсний талбайн нөөцийн нүүрсний давхраанууд нь газрын гадаргууд харьцангуй ойр тул ил уурхайн аргаар авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно.

Хүснэгт 3. Ашиглалтын технологийн схем

| Ашиглалтын систем | Үндсэн ажил | Технологийн процессууд |
|---|---|---|
| Тээвэртэй ашиглалтын технологи | 1. Хөрс хуулалт | Өрөмдлөг тэсэлгээ<br>Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Олборлох |
| | 2. Олборлолт | Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Овоолох |

**Дэд бүтэц.**

Зам харилцаа.

Хөөтийн хонхор-2 төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн-урагш 340 км-т Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Дундговь аймгийн Мандалговь хотоос зүүн урагш 130 км, Баянжаргалан сумаас баруун зүгт 25 км-т байрлана. Уурхайн талбайд жилийн аль ч улирал Баянжаргалан сум юм уу аймгийн төв Мандалговь хотоос шороон замаар очих боломжтой.

Цахилгаан хангамж.

"Хөөтийн хонхор-2" уурхайн ойролцоо "МАК" ХХК-ийн татсан 35/10 кВ-ын өндөр хүчдэлийн шугамд холбогдсон байдаг. Уурхайн цахилгааны хэрэглээг "МАК" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хангадаг.

Усан хангамж.

Уурхайн ашиглалтын үед унд ахуйн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайд гаргасан 1.1 л/с ундаргатай гүний худгаас хангана. Зам талбайн усалгаа болон ногоон байгууламжийн усалгааг уурхайн карьерт орж ирэх шүүрлийн усаар хангана.

Хөөтийн хонхрын уурхайн баруунд урд хэсэгт 25 орчим гүнээс газрын доорх ус шүүрч уурхайн олборлолтыг зогсоож, карьерын зүүн талын мөргөцгөөс олборлолт явуулж байна.

Олборлолтын явцад үүссэн шүүрлийн усыг зумпын аргаар соруулж уурхайн карьераас 2.5 км зайд байгальд задгай байдлаар шингээж байна.

**Унд ахуйн хэрэглээний ус ашиглалт.**

Унд ахуйн усны хэрэглээг БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/301 дугаар тушаалаар баталсан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 12 дугаар хавсралтыг үндэслэж тооцов.

Хүснэгт 4. 2024 онд унд ахуйн хэрэглээнд ашигласан усны тооцоо

| Нийт ажилчдын тоо | Нэг хүний хоногт ашиглах усны норм, л | Жилд ажиллах хоног | Нийт ашиглах усны хэмжээ, м3 |
|---|---|---|---|
| 160 | 150 | 326 | 7,824 |

- Уурхайн бүс орчмын газрын гүний ус нь эрдэсжилт болон хатуулаг өндөртэй байдаг тул унд ахуйн хэрэглээнд зөөлрүүлэн ашигладаг.

| Унд ахуйн ус цэвэршүүлэгч | Уурхайн гүний худаг |
|---|---|
|  |  |

Ногоон байгууламжын усалгаа.

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 05-р сард уурхайн кемпийн гадна нийт 500 ширхэг хайлаас мод суулгацаар шуудуулан тарихаар төлөвлөсөн.

Ногоон байгууламжийн усалгаанд ашигласан усны хэрэглээг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/301 дугаартай тушаалын хавсралтаар баталсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормд заасан 1 ш суулгац услах усны норм /40 л/-оор тооцлоо.

Хүснэгт 5.Ногоон байгууламжын усалгаанд ашигласан усны хэрэглээ

| Суулгацын тоо, ш | 1 ш суулгац услах норм, л | Усалгаа хийх хоногийн тоо | Нийт ашиглах усны хэмжээ, м3 |
|---|---|---|---|
| 500 | 40 | 32 | 640 м3 |

Зам талбайн тоосжилт дарахад ашигласан усны хэмжээ.

Уурхайн зам талбайн тоосжилтыг дарахад 20 тн-ийн багтаамжтай усны машин ашигладаг.

Хүснэгт 6.

| Замын урт | 1 м2 зам услахад шаардагдах усны норм, л | Зам усалгаа хийх хоног | Нийт ашиглах усны хэмжээ, м3 |
|---|---|---|---|
| 30 000 м2 | 2 | 125 | 7 500 |

Уурхайн үйл ажиллагаанаас гарах хаягдал ус

**Ахуйн хэрэглээний бохир ус.** Ахуйн бохир усыг цооногт хуримтлуулж, соруулах байдлаар шийдсэн.

2024 онд уурхайн кемпийн гадна ашиглаж байсан хөрсний бохирдол үүсгэж буй нүхэн жорлонг булж эко нойл байгуулсан.

Эко 00-ийг байгуулахдаа бохир цуглуулах 25 тн-ийн багтаамжтай төмөр танк суурилуулсан бөгөөд Дундговь Ус ОНӨААТҮГ-тай бохир ус соруулах гэрээг байгуулан ажиллаж байна.



*Зураг 1.Бохир хуримтлуулах 25 тн багтаамжтай танк суурилуулсан байдал.*

## ХОЁР. АШИГЛАЛТЫН ТАЛБАЙ ОРЧМЫН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ

**Талбайн газарзүйн байршил.**

Ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутагт нийт 1046.73 га талбайг хамран Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан сумдын нутгийн заагт баруун талаараа Баруун хүрийн ухаа, зүүн талаараа Талын хоолой, Талын худгийн хөндий, хойд талаараа Хар хадны толгодоор оршдог.

Орд орчмын район нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их муж, Дорнод говийн муж, Умард говийн ухаа толгодот талын тойрогт хамаарах бөгөөд байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд багтаж байна.

Сав газрын ангиллаар Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт харъяалагдана.




*Зураг 2. “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордын байршлын зураг*

**Цаг уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд**

Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хойд хэсэг хуурай хээрийн бүсэд, урд хэсэг цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Аймгийн нутагт дулааны хангамж сайн боловч чийгийн хангамж бага, жилд орох хур тунадасны хэмжээ нутгийн хойт хэсэгт 200-250 км, төв хэсэгт 150-200 мм, өмнөд хэсэгт 100-150 мм байдаг. Жилийн салхины дундаж хурд 4-6 м/с, хамгийн их хурд 38-40 м/с хүрдэг. Уур амьсгалын хувьд халуун зунтай, цас багатай зөөлөвтөр өвөлтэй дэд мужид хамрагддаг. Ус чийг багатай учир манан бараг ажиглагдаггүй, хур тунадасны хэмжээ жилд 150 мм-ээс бага бөгөөд түүний 80 хувь нь 7-8-р сард унадаг ажээ. Хоногийн хэмийн хэлбэлзэл уул нурууны хоорондох хөндий, хоолойд харьцангуй бага, талбайн баруун хэсгээр нилээд их байдаг. Энэ нь салхийг хаах өндөр уул, нуруud байхгүйтэй холбоотой юм. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 10-15 хоног, хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд дунджаар 6.9 м/с, хамгийн бага салхилалт өвөл буюу 4.2-4.3 м/с байдаг байна. Жилийн салхины дундаж хурд 4 м/с бөгөөд жилд дунджаар 30-35 хоног 15 м/с хүртэл хүчтэй цасан ба шороон шуургатай өдрүүд тохиолдоно.

**Хөрсөн бүрхэвч.**

Тус талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар цайвар хүрэн хөрсний дэд бүс Баяндэлгэрийн 8-р тойрогт багтана. Эндхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгүй байдаг учраас салхины үйлчлэлд хялбар өртөж хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэнцэр хөрстэй газраар байнга ажиглагдана. Цайвар хүрэн хөрсний гадарга дээр хөдөлгөөнтэй хэмхдэс сайр чулуу ихтэй, өнгөн хөрс их хуурайшилттай, хөрсний дээд давхарга элсэнцэр бүрэлдэхүүнтэй. Хөрс шим тэжээлийн бодисын хангамжаар бага, хөрсний үржил шимт чанар дунд зэрэг, механик бүрэлдэхүүнээр өнгөн давхарга нь элсэнцэр, элсэрхэг бүрэлдэхүүнтэй байгаагаар онцлогтой байна.

“Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төлсийн 2024 онд хийгдсэн БОННҮ-ний нэмэлт тодотголын ажлын хүрээнд хийсэн хөрсний морфлогийн бичиглэлийн үр дүнгээс үзэхэд ашиглалтын талбай орчимд цайвар хүрэн хөрс, хүрэн хөрс зонхилох бөгөөд хөрсний дундаж зузаан нь 10-20 см байна.

**Ургамлан нөмрөг.**

Монгол орны ургамал газарзүйн тойргоор энэ бүс нутаг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Энэ тойрогт 793 зүйл ургамалтай бөгөөд зөвхөн энэ тойрогт ургадаг 1 зүйл (Papaver rubro-aurantiacum)ийн ургамалтай. Дундад Халхын тойргийн үндсэн төрхийг үзүүлэх зүйлүүд: Жижигнавчит харгана (Caragana microphylla), Япон хайлаас (Ulmus pumila), Бариулт бүйлэс (Amygdalus pedunculata), Дэрэвгэр тарна (Polygonum divaricatum, Дорнодын хамхуул (Corispermum orientale), Дэрвээн цульхир (Agriophyllum pungens), Монгол хамхуул (Corispermum mongolicum), Үслиг мананхамхаг (Bassia dasyphylla), Козловын сүүт-өвс (Euphorbia kozlovii), Сибирь шорной (Atriplex sibirica), Эрлийз лууль (Chenopodium hybridium), Клеменцийн ортууз (Oxytropis klementzii), Хангайн шарилж (Artemisia changaica), Толгодын багваахай(Taraxacum collinum) зэрэг болно.

**Амьтны аймаг.**

“Хөөтийн хонхор-2” нүүрсний ордын бүс нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол дагуурын хээрийн дэд муж, Монгол дагуурын хээрийн тойргийн урд зах, Дорноговийн хээрийн тойргийн хойд захад хамаарна.

**Усан орчны төлөв байдал.**

Гадаргын усны төлөв байдал. Энэ бүс нутаг ус зүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон "Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар"-т хамаарна.

Умард говийн усны сав газар нь 8 аймаг, 59 сум, Нийслэлийн Багахангай дүүргийн газар нутгийг хамарсан нийт 180404.2 км2 талбай бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам нутаг юм. Умард говийн усны сав газар нь Монгол орны төв ба дундад халхын тал, өмнөд болон зүүн өмнөд говийн бүсийн хур тунадас багатай нутаг дэвсгэрт хамаарагддаг бөгөөд Дундговь аймгийн 92.7 хувь нь тус сав газарт харъяалагдана. Газрын гадаргын хувьд баруун хагас нь уулархаг бөгөөд нутгийн ихэнх хэсэг ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар болно. Энэ бүс нутагт гадаргын ус нэн ховор. Сав газрын баруун хойд хэсгээр (Өвөрхангай аймаг) Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдах гол цөөн тоотой бий. Харин говийн бүсэд түр зуурын уруйн ус урсах хуурай сайрууд маш түгээмэл ажиглагддаг. [https://water.gov.mn/savgazar/113]

"Хөөтийн хонхор"-2 уурхайн ойр орчимд хамгийн ойр орших гадаргын ус нь Хөөтийн булаг бөгөөд жилийн дөрвөн улиралд устай байх боловч цаг уур хуурайших тутамд ус нь татарч багассаар хатдаг байна.

Талбайн гидрогеологийн нөхцөл. "Хөөтийн хонхор"-2 ордыг ашиглах төслийн ТЭЗҮ-ийн тайлангын нэмэлт тодотголын ажлыг 2023 онд "МАЙНДАТА" ХХК-аар гүйцэтгүүлсэн.

ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголын ажлын хүрээнд уурхайн ашиглалтын талбай орчмын гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор "Хөөтийн хонхор"-2 талбайн хайгуулын ажлын үед гидрогеологийн судалгааны зориулалтаар өрөмдсөн Н-1, Н-2, Н-3, Н-2А цооногуудад гидрогеологийн ажиглалт хийх мөн цооногуудад усны түвшин хэмжих, тус талбайд тархсан газрын доорх усыг илрүүлэх, байршлыг тогтоох, газрын доорх усны тархалт, хуримтлал, түүний хөдөлгөөн, чиглэл, хил хязгаарын нөхцөлийг тогтоох ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ингэхдээ хээрийн ажлын явцад өрөмдсөн гидрогеологийн цооногуудад каротажийн судалгаа явуулж үр дүнг өрөмдлөгийн үеийн гидрогеологийн ажиглалт, туршилтын ажлын үр дүнтэй харьцуулан уст үеийн байршил, зузааныг тогтоосон болно. Үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүд

| Цооног дугаар | Ус илэрсэн гүн, м | Тогтоосон түвшин, м | Уст үеийн зузаан, м | Ус агуулагч чулуулгийн тодорхойлолт |
|---|---|---|---|---|
| Н-1 | 10.0 | 10.0 | 38.0 | Элсэн чулуу, гравелитын салаавчилсан үе |
| Н-2 | 12.0 | 7.0 | 34.4 | Элсэн чулуу, аргиллит, нүүрс, салаавчилсан үе |
| Н-3 | 12.0 | 11.0 | - | Нурсан, гүн-27.0 м |
| Н-2А | 12.7 | 7.0 | 34.4 | Элсэн чулуу, аргиллит, салаавчисан үе |

## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Хөөтийн хонхор”-2 нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн “БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлан”-нд тодорхойлсноор төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт дараах эерэг болон сөрөг нөлөөг үзүүлэхээр байна.

### *3.1.* Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөлөл

Тоосны бохирдол.

- Уурхайн тээрэлэлтийн явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан гадаад болон дотоод тээврийн замаас тоосжилт үүснэ,
- Ашигт малтмал олборлолтын явцад тэсэлгээгээр суларсан хөрснөөс тоосжилт үүснэ ,
- Хөрсний овоолго үүсгэх үед автомеханизм болох утгуурт ачигчийн үйл ажиллагаагаар орчны агаарт тоос, тоосонцор ялгарна.

Хорт хийн бохирдол.

Уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах угаарын хий (CO), азотын дутуу исэл (N2O), хүхэрлэг хий (SO2) зэрэг хорт хий нь тухайн орчны агаарын чанарт нөлөөлнө.

### *3.2.* Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл

Газрын эвдрэл.

Уурхайн ашигт малтмал олборлох малталтын талбай, хөрсний овоолго үүсгэх хэсэг, гадаад болон дотоод тээврийн зам, уурхайн барилга байгууламж зэргийг барьж байгуулах, ашиглах явцад газрын гадарга, хөрсөн бүрхэвч эвдэрч байгалийн унаган төрхөө алдана. Төсөл хэрэгжих 9 жилийн хугацаанд 17.32 сая $м^3$ хөрс хуулж 8.75 сая.тн нүүрс олборлоно. Өнөөгийн байдлаар уурхайн ухаш 25 м гүн байгаа бөгөөд ашиглалтын хугацаанд нийт олборлолтод өртсөн нийт талбайн хэмжээ 68.23 га байна.

### *3.3.* Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагааны явцад карьер болон овоолгууд, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих, ашиглах үед тухайн орчны ургамлан бүрхэвч хөрстэй цуг хуулагдан устана. Мөн замын тоос, шороо, авто машины хөдөлгүүрээс ялгарах хорт хий зэргээр эргэн тойрны ургамлан нөмрөг дарагдах, бохирдох, тухайн орчны ургамлын өсөлт удаашрах, төрөл зүйлийн тоо буурах, өөрчлөгдөх эрсдэлтэй.

### *3.4.* Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл

Тухайн бүс нутгийн хөхтөн амьтдын тархац нутаг хумигдах, тоо толгой буурах, хүн, машин техникийн хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэргээс амьтад дайжих г.м амьтны аймагт шууд биш ч дам байдлаар сөрөг нөлөө үзүүлнэ.

### 3.5. Газрын гадарга болон гүний усанд учруулах сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд ил урсацтай булаг шанд байхгүй ба Хөөтийн булаг нь уурхайн талбайгаас 1.8 км зайд оршино.

Уурхайн үйл ажиллагааны үед хог хаягдал ил задгай хаях, шатах тослох материал алдагдах зэргээс үүдэн газар доорх ус болон булгийн усыг бохирдуулж болзошгүй байна. Төслийн унд ахуйн ус хэрэглээг уурхайн талбайд байрлах 1.1 л/с-н ундаргатай гүний худгийн уснаас, уурхайн өрөмдлөгийн ажлын усны хэрэглээг уурхайн шүүрлийн уснаас хангана. “Хөөтийн хонхор”-2 ордын гидрогеологийн нарийвчилсан судалгаагаар уурхайн олборлолтын явцад хоногт 87.264 $м^3$ шүүрлийн ус үүсэх бөгөөд жилд 31,937.50 $м^3$ ус соруулахаар байна. 2025 онд ашиглах усны дүгнэлтээр унд ахуйн хэрэглээнд 7,938.75 $м^3$ зам талбайн тоосжилт дарахад 7500 $м^3$, ногоон байгууламжын усалгаанд 900 $м^3$ ус буюу нийт 16,338.75 $м^3$ ус ашиглахаар тооцсон. Иймд уурхайн үйл ажиллагаанаас гүний усны нөөцөд бага зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### *3.6.* Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал орчны эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх.

Төслийн үйл ажиллагаанаас дараах хог хаягдлууд үүснэ.

Хүснэгт 7. Үүсэх хог хаягдлын төрөл

| Үүсэх хог хаягдлын төрөл | Хог хаягдлын ангиллаар |
|---|---|
| **Ахуйн хэрэглээний хатуу хог хаягдал** | Энгийн хог хаягдал |
| **Ахуйн хэрэглээний шингэн хог хаягдал** | Энгийн хог хаягдал |
| **Засварын талбайгаас үүсэх хатуу хог хаягдал** | Барилгын материалын хаягдал |
| **Үнсний хаягдал** | Энгийн хог хаягдал |
| **Ашигласан тос тосолгооны материалын хаягдал** | Аюултай хог хаягдал |

- Хог хаягдлыг ил задгай хаях,
- Шаардлага хангаагүй хогийн саванд хадгалах,
- Дулааны улиралд хог хаягдлыг хэт удаан хадгалах,
- Засварын талбайд үүсэх төмрийн хаягдлыг төвлөрсөн нэг цэгт байрлуулахгүй байх,
- Ашигласан тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдсан тохиолдолд хариу арга хэмжээ авахгүй байх,
- Ахуйн хэрэглээнээс үүссэн шингэн хог хаягдлыг ил асгах, хөрсөнд нэвчүүлэн зайлуулах нь орчны агаар, хөрсний шимт чанар, Хөөтийн булгын усны чанар, урсац зэрэгт сөргөөр нөлөөлнө.

### *3.7.* Нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөлөл

- Уурхайн үйл ажиллагааны туршид Баянжаргалан сумын иргэд болон нөлөөллийн бүсийн иргэдийн амьдралын хэв маяг, эрүүл мэндэд шууд болон дам байдлаар эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас улс болон орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох, ядуурлыг бууруулах зэргээр нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Төсөл хэрэгжсэнээр жил тутам 7.4-10.6 тэрбум төгрөг, нийт ашиглалтын хугацаанд 84.14 тэрбум төгрөгийг төрөл бүрийн хэлбэрээр улсын болон орон нутгийн төсөвт оруулж байгаа нь нийт борлуулалтын орлогын 21.4%-тай тэнцэхээр байна. Төслийн хугацаанд улсын төсөвт 46.0 тэрбум төгрөг, орон нутагт 38.15 тэрбум төгрөг оруулна.

## ДӨРӨВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбайн орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОАЖЯ нь төслийн БОМТ-г батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Засаг дарга, БОАЖЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй.

БОМТ нь доорх үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө,
- Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүх л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Төслийн 2025 оны БОМТ-ний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө 2024 онд батлагдсан БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлангийн БОХТ-ний хэсэгт 2025 онд хийхээр тусгасан арга хэмжээ болон 2025 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулж, мөн тус төслийн үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны аудитын тайлангийн дүгнэлт зөвлөмж, орон нутгаас өгсөн санал зөвлөмжүүдийг нэмэлтээр тусган боловсруулав.

2024 оны БОМТ-ний биелэлтийг орон нутгаас томилогдсон ажлын коммист 2024 оны 12-р сарын 20-ны өдөр 90.5 хувийн үнэлгээтэйгээр дүгнүүлсэн бөгөөд 2025 оны БОМТөлөвлөгөөнд орон нутгаас өгсөн саналын дагуу дараах ажлуудыг оруулав.

Хүснэгт 8. Орон нутгаас өгсөн санал

| № | Орон нутгаас өгсөн санал | Орон нутгаас өгсөн саналын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан ажлууд |
|---|---|---|
| 1. | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан бохирдлын үзүүлэлт тодорхойлох үедээ нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулан хэмжилтийг хийх, сүүлийн 2-3 жилийн мониторингийн үр дүнд суурилан гарсан бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөх | БОАЖ-ын сайдын 2023 оны А/160 тоот тушаалаар Байгаль орчин судалгаа, шинжилгээний төвөөс 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр манай “Биг могул коул энд энержи” ХХК-ийн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт хэрэгжиж буй ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор”-2 нүүрсний ордыг ашиглах төслийн талбайд хийсэн бохирдлын судалгааны тайланд тусгасан хөрс, ус, агаарын чанарын судалгааны үр дүн,<br>2024 онд ОХШХ-ийн хүрээнд төслийн талбайгаас авсан хөрс, ус, агаарын сорьцын шинжилгээний үр дүнд харьцуулалт хийж 2025 оны БОМТ-ний ОХШХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргасан. |
| 2. | “Тэр бум мод” үндэсний | Орон нутгаас ирүүлсэн саналын дагуу төсөл хэрэгжих |

| | | |
|---|---|---|
| | хөдөлгөөн, “Дундговио ногооруулья” дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар сум орон нутгийн байгууллагатай зөвшилцөн төлөвлөж, үр дүн гарган ажиллах. | Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт “Биг могул коул энд энержи” ХХК-ийн нэр дээр мод тарих талбай заалгах, тус талбайд бүс нутгийн байгаль цаг уурын онцлогт тохирсон 500 ш мод тарьж ургалт, арчилгааг манай “Биг могул коул энд энержи” ХХК хариуцаж ажиллах. |
| **3.** | Гүн өрмийн худаг болон шүүрлийн усыг тоолуурлжуулах | Усны нөөц, чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэсэгт уурхайн унд ахуйд ашигладаг гүний худаг болон шүүрлийн ус соруулж буй хэсэгт мэргэжлийн байгууллагатай хамтран тоолуур суурилуулах ажлыг төлөвлөсөн. |
| **4.** | Шүүрлийн усыг орон нутгийн захиргаа, нөлөөллийн бүсийн иргэдийн саналыг харгалзан дахин ашиглах байдлаар шийдвэрлэх | Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулах талаар усны мэргэжлийн байгууллага эсвэл усны нарийн мэргэжилтэнтэй хамтран суурь судалгааны ажлыг хийж, үр дүнг орон нутагт танилцуулна. |
| **5.** | Ахуйн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах цэгт тушаах | Тус ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:<br>— Хог хаягдыг эх үүсвэр дээр нь цуглуулах, ангилан ялгах, хадгалах, тээвэрлэх тухай дотоод журам боловсруулж батлах,<br>— Нийт ажилчдад хог хаягдал ангилан ялгах талаар сургалт орох,<br>— Ажилчдын хэрэглээнээс үүссэн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж дахин боловсруулах боломжтой хог хаягдлын сард үүсэх хэмжээг тодорхойлох,<br>— Ахуйн хэрэглээнээс гарсан хуванцар савыг цуглуулж сум эсвэл аймгийн дахивар авах цэгт тушаах,<br>— Ашигласан тос тосолгооны материалын хаягдлыг гэрээлэгч компанид улиралд нэг удаа нийлүүлэх |
| **6.** | Автомашин засварын цэгийг бетонжуулах, тэмдэг тэмдэглэгээ хийх | Засварын талбайг ШТМ-аар хөрс бохирдохоос сэргийлэн хатуу хучилттай болгох, мөн засвар хийх талбай, техник зогсох хэсэг, засвараас гарсан хог хаягдлыг байрлуулах хэсгийг тэмдэгжүүлэх |
| **7.** | Нүхэн жорлонг буулгах | — Хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонг буулгах |
| **8.** | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Аргын хад” орон нутгийн тусгай хамгаалалттай газарт зэрлэг ан амьтан ундаалах зорилгоор хөв цөөрөм | Хөв цөөрөм байгуулах талаар усны мэргэжлийн байгууллага эсвэл усны нарийн мэргэжилтэнтэй хамтран суурь судалгааны ажлыг хийх. |

| | | |
|---|---|---|
| | байгуулах | |
| **9.** | Ахуйгаас гарч буй бохир шингэн хаягдлыг зориулалтын шаардлага хангасан байгууламжид цуглуулах | — Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг бохирын цооногт хуримтлуулж, мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан цооног дүүрэх үед соруулах<br>— Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлэх |
| **10.** | Нөлөөллийн бүсийн иргэдэд үйл ажиллагааг танилцуулж, санал хүсэлтийг хүлээн авч ажиллах (шүүрлийн усаар мал, амьтан услах усан сан байгуулах, ногоон тэжээл тариалах, бэлчээр хашихад дэмжлэг үзүүлэх зэрэг санал гарсан). | БОМТ-ний хэрэгжилтийг 2025 оны дөрөвдүгээр улиралд багийн иргэдийн нийтийн хурлаар танилцуулан, иргэдээс санал хүсэлтийг цуглуулна.<br>2025 онд хөв, цөөрөм байгуулах талаар суурь судалгаа хийж үр дүнг багийн иргэдэд танилцуулна.<br>Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөлөөллийн бүсийн иргэдтэй хамтран бэлчээр хашаалах ажилд уурхайн зүгээс дэмжлэг үзүүлнэ. |

**"Хөөтийн хонхор-2" уурхайн 2023, 2024 онуудад хийсэн ус, хөрс, агаарын шинжилгээний үр дүн**

Төслийн талбайн ус, хөрс, агаарын чанар, бохирдлын түвшинг үнэлэхдээ 2023, 2024 онд хийгдсэн дараах суурь мэдээ, материалуудыг ашиглав.

- БОАЖ-ын сайдын 2023 оны А/160 тоот тушаалаар Байгаль орчин судалгаа, шинжилгээний төвөөс 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр манай "Биг могул коул энд энержи" ХХК-ийн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт хэрэгжиж буй ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай "Хөөтийн хонхор"-2 нүүрсний ордыг ашиглах төслийн талбайд хийсэн орчны хяналт шинжилгээний тайланд тусгасан хөрс, ус, агаарын чанарын судалгааны үр дүн,
- 2024 оны ОХШХ-ийн хүрээнд 4 болон 10-р сарууд хийгдсэн хөрс, ус, агаарын сорьцын шинжилгээний үр дүн
- 2024 онд төслийн үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны аудитын тайлангийн дүгнэлт зөвлөмжүүд

**2023 онд Байгаль орчин судалгаа, шинжилгээний төвөөс хийсэн байгаль орчны бохирдлын судалгааны үр дүн**

Хүснэгт 9. Дээж авсан цэгийн байршил

| Сорьц авсан газрын нэр | Төрөл Стандарт | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|---|
| **Усны сорьц авсан цэгийн байршил** | | | |
| **Ундны ус, шүүлтүүртэй** | MNS0900:2018 | 45.71867 | 107.6997 |
| **Булаг** | | 45.71187 | 107.6933 |
| **Шүүрлийн ус** | MNS4586:1998 | 45.71202 | 107.704 |
| **Хөрсний сорьц авсан цэгийн байршил** | | | |
| **Карьер** | | 107.70197 | 45.71239 |
| **Хаягдал хөрсний овоолго** | | 107.69578 | 45.71503 |

| | | | |
|---|---|---|---|
| **Засварын төв** | | 107.70000 | 45.71811 |
| **Аюултай хог хаягдал** | | 107.69950 | 45.71767 |
| **Төмрийн хаягдал** | | 107.69911 | 45.71792 |
| **ШТС** | | 107.70311 | 45.71800 |
| **Шимт хөрсний овоолго** | | 107.70433 | 45.72319 |
| **Кемп** | | 107.70006 | 45.72086 |
| **Хяналт** | | 107.70625 | 45.72919 |
| **Карьер** | | 107.70053 | 45.69908 |
| **Хаягдал хөрсний овоолго** | | 107.70539 | 45.69828 |
| **Засварын төв** | | 107.70944 | 45.70806 |
| **Нүхэн жорлон** | | 107.70128 | 45.72189 |
| **Энгийн хог хаягдал** | | 107.70072 | 45.72200 |
| **Энгийн хог хаягдал** | | 107.70933 | 45.70572 |
| **Нүхэн жорлон** | | 107.70975 | 45.70550 |
| **Агаарын чанар, тоосжилтын шинжилгээний сорьц авсан цэгүүд** | | | |
| **Карьер** | MNS 4585:2016 | 107 42 07.1 | 45 42 44.6 |
| **Кемп** | MNS 4585:2016 | 107 42 00.0 | 45 43 15.1 |
| **Шатаж буй овоолгын урд** | MNS 4585:2016 | 107 42 24.4 | 45 42 02.1 |

**2023 онд хийгдсэн шинжилгээний үр дүнгээр:**

**Усны химийн шинжилгээний үр дүн.** Тус судалгааны ажлын хүрээнд ундны усны 1 цэг, гадаргын усны 2 цэгээс сорьц авч, усны pH, эрдэсжилт, цахилгаан дамжуулах чанар, ууссан хүчилтөрөгч, исэлдэн ангижрах чанар, булингар, давсжилт зэрэг үзүүлэлтүүдийг хэмжсэн байна.

Уурхайн ундны ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлорид ангийн натрийн бүлгийн, I төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал, ундны ус, эрүүл ахуйн чанар, байдлын үнэлгээ стандартын хүлцэх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байгаа тул хүний эрүүл мэнд болон унд ахуйд тохиромжтой ус байна.

Хөөтийн булгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, натрийн бүлгийн, I төрлийн, чанарын хувьд давстайвтар, маш хатуу ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS4586:1998 стандартын хүлцэх дээд хэмжээнээс сульфатын агууламж, 2.79 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байсан байна.

Уурхайн шүүрлийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, натрийн бүлгийн, I төрлийн, чанарын хувьд давстайвтар, маш хатуу ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс MNS4586:1998 стандартын хүлцэх дээд хэмжээнээс сульфатын (SO4) агууламж 4.8 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Нийт уст цэгийн усны сорьцод агуулагдах бичил элементүүдийн агууламж MNS0900:2018 болон MNS4586:1998 стандартуудад заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байгаагүй

**Усны эрдэсжилт.** Сорьц авсан 3 уст цэгийн ус нь эрдэсжилтийн агууламжаар нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэйгээс давстайвтар буюу их эрдэсжилттэй (16-2809 мг/г) ангилалд хамаарагдаж байна. Эрдэсжилтийн агууламж нь стандартын

хүлцэх дээд хэмжээнээс (<1000 мг/л) 2.4-2.8 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

**Усны ерөнхий хатуулаг.** Уст цэгүүдийн сорьцын химийн шинжилгээний дүнг MNS 0900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд унд ахуйн усны сорьц стандарт хэмжээнд байв. Хатуулгаар нь ангилбал маш зөөлнөөс маш хатуу (0.08-21.79 мг-экв/л) ангилалд хамаарагдаж байна. Гадаргын усны 2 сорьцын ерөнхий хатуулаг нь стандартын хүлцэх дээд хэмжээнээс 2.3-3.1 дахин хэтэрсэн байна.

**Хөрсний бохирдлын шинжилгээ**. Судалгаагаар нийт 7 цэгээс хөрсний өнгөн үе давхаргын дээж авч химиं, физик, микробиологийн шинжилгээнд хамруулсан. Судалгаанд хамрагдсан бүх дээж ялзмагийн агууламжаар бага. Хөрсний урвалын орчин саармаг болон шүлтлэг. S-6 сул давсжилттай, бусад дээж давсжилтгүй. Хөрсний физик шинжийн хувьд элсэнцэр болон элсэрхэг механик бүрэлдэхүүн давамгайлсан байна. Микробиологийн шинжилгээгээр хогийн цэг орчмоор халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тарьц илрэв, мөн клостридиум перфрингенсийн тарьц илрэв. Хөрсний хүнд металлын бохирдлын хувьд S-2 дээж буюу Хаягдлын овоолгод хүнцэл (As)-ын агууламж, монгол улсын стандарт хүлцэх хэмжээ болон элсэнцэр хөрсний хүлцэх хэмжээнээс аль алинаас нь давсан байна. Молибден (Mo) Хаягдлын овоолго болон хүдрийн овоолго орчимд элсэнцэр хөрсний хүлцэх агууламжаас давсан үзүүлэлттэй. Молибден, Ванади, Цайрын агууламж элсэнцэр хөрсний хүлцэх хэмжээнээс давсан боловч монгол орны стандарт хүлцэх агууламжаас даваагүй. Кадми, Кобальт, Хром, Зэс, Никель, Хар тугалга, Стронци хүлцэх хэмжээнээс бага агууламжтай байна.

**Агаарын тоосжилт.** Уурхайн карьер, кемп, шатаж байсан овоолгын урд буюу нийт 3 цэгт том ширхэгт тоосонцрын хэмжээг MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд агууламжаас хэтрээгүй байна.

**2024 оны ОХШХ-ийн хүрээнд авсан сорьцын шинжилгээний үр дүн**

**1. Хөрсний шинжилгээний үр дүн**

Харьцуулсан стандарт, үзүүлэлтүүд:

- Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS3310:1991
- Хөрсний чанар. pH-ыг тодорхойлох. MNS ISO 10390-2001
- Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019

1. Хөрсний урвалын орчин

| **pH** | **5-аас бага** | **0.5-0.6** | **6.1-6.5** | **6.6-7.3** | **7.4-7.8** | **7.9-8.4** | **8.5-9** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Түвшин** | Хүчтэй хүчиллэг | Дунд зэрэг хүчиллэг | Сул хүчиллэг | Саармаг | Сул шүлтлэг | Дунд зэргийн шүлтлэг | Хүчтэй шүлтлэг |

2. Хөрсний ялзмагын агууламж

| **Ялзмаг** | **0-2 %** | **2-5 %** | **5%-иас дээш** |
|---|---|---|---|
| **Түвшин** | Бага | Дунд | Их |

3. Давсжилт

| Давсжилт | 0.75-аас бага | 0.75-2 | 2-4 | 4-8 | 8-15 | 15-аас дээш |
|---|---|---|---|---|---|---|
| Түвшин | Давсгүй | Сул давстай | Дунд зэрэг давстай | Өндөр давстай | Маш өндөр давстай | Хэт их давстай |

4. Хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт химийн нэгдлийн агууламж

| Хөдөлгөөнт фосфор (P2O5) | <1 | <1.5 | 1.5-3.0 | 3.0-4.5 | 4.5-6.0 | >6.0 |
|---|---|---|---|---|---|---|
| Түвшин | Хэт бага | Бага | Дунд | Дундаас их | Их | Хэт их |
| Карбонат (CaCO2) | 0 | 0.1-2 | 2-10 | 10-25 | 25-аас дээш | |
| Түвшин | Карбонатгүй | Сул кабонаттай | Дунд зэрэг | Хүчтэй карбонаттай | Маш хүчтэй карбонаттай | |
| Хөдөлгөөнт кали (K2O) | 10-аас бага | 10-20 | 21-30 | 31-40 | 41-50 | 50-аас дээш |
| Түвшин | Хэт бага | Бага | Дунд | Дундаас их | Их | Хэт их |

**2024.04-р сар**

2024 оны 04 сард Дундговь аймгийн УЦУОХШГазартай хамтран дараах цэгүүдээс хөрсний дээж авч сорьцод агуулагдах ялзмаг, pH, хөдөлгөөнт фосфор, сульфатын агууламж, нитратын ион, аммионы агууламжийг тодорхойлуулсан.

Хүснэгт 10. Дээж авсан цэгийн байршил

| Сорьц авсан цэг | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хөрсний чанарын үзүүлэлтүүд | | Ажилчдын байр | Технологийн зам | Засварын завод | ШТС |
| **pH** | | 7.874 | 7.505 | 7.831 | 7.321 |
| **Ялзмаг** | | 1.79 | 1.83 | 1.70 | 1.94 |
| **NO3 мг/кг** | (мг/100гр) | 16.72 | 27.17 | 50.54 | 16.53 |
| **NH4 мг/кг** | | 45.44 | 117.83 | 98.57 | 100.88 |
| **SO4 мг/кг** | | 1768.0 | 2650.0 | 2267.0 | 26.7 |
| **P2O5 мг/кг** | | 9.680 | 51.304 | 46.024 | 50.248 |



Ялзмаг нь хөрсний үржил шимийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог. Хөрсөнд хэдий чинээ их ялзмаг агуулагдана, төдий чинээ ус, агаар, дулааны болон физик-механикийн шинж чанар сайн байна.




Уурхайн орчмын хөрсөнд агуулагдах ялзмагийн агууламж бага, Хөрсний урвалын орчин (pH) сул шүлтлэг, ажилчдын байр, технологийн зам, засварын заводын хөрсөнд агуулагдах сульфатын агууламж өндөр, ШТС-ын хөрсөнд агуулагдах сульфатын агууламж бага байна, нитратын ион 16.72-50.54 мг/100 гр, аммионы агууламж 45.44-117.83 мг/100 гр хооронд хэлбэлзэж байна.

Хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфорын агууламж нь хөрсний үржил шимт чанарыг илэрхийлэх үзүүлэлт байдаг. Сорьцуудад агуулагдах хөдөлгөөнт фосфорын агууламж 9.680-51.304 мг/100гр (<1) хооронд буюу хэт бага байна.




**2024 оны 10-р сар**

2024 оны 10-р сард доорх цэгүүдэд хөрсний өнгөн хэсгээс дээж авч хөрсний ерөнхий химийн шинж чанарын үзүүлэлтүүд, хүнд металлын агууламжуудыг “Инженер гиодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан.

Хүснэгт 11. Хөрсний химийн шинж чанар.

| Дээжний нэр | pH | Давс | Цахилгаан дамжуулах чанар | Ялзмаг | NO3 | CaCO2 | Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ca | Mg | P2O5 | K2O |
| Нүхэн жорлон | 8.81 | 0.07 | 0.157 | 1.96 | 0.22 | 0.16 | 5.0 | 3.3 | 1.4 | 30 |
| Хогийн цэг | 8.49 | 0.60 | 1.205 | 0.44 | 0.16 | 0.49 | 16.0 | 12.4 | 2.4 | 11 |
| Машин зогсоол | 8.63 | 0.41 | 0.826 | 0.36 | 0.11 | 0.32 | 9.9 | 6.7 | 1.3 | 16 |
| Кемп | 8.84 | 0.13 | 0.262 | 0.62 | 0.13 | 0.16 | 5.8 | 4.8 | 1.1 | 14 |
| ШТМ хадгалах | 8.97 | 0.14 | 0.292 | 0.19 | 0.05 | 0.32 | 5.7 | 4.4 | 0.4 | 12 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| агуулах | | | | | | | | | | |
| Засварын талбай | 8.79 | 0.53 | 1.169 | 1.83 | 0.28 | 0.66 | 10.6 | 6.7 | 2.2 | 12 |







.

Хөрсөнд агуулагдах ялзмагийн агууламж бага, давсжилт 0.07-0.60 % -ийн хооронд буюу давсгүй, хөрсний урвалын орчин (pH) хүчтэй шүлтлэг, хөдөлгөөнт фосфор ($P_2O_5$)-ын агууламж штм хадгалах агуулахын дэргэдээс авсан дээжид 0.4 мг буюу хэт бага, бусад цэгт 1.1-2.4 мг хооронд буюу бага хэмжээтэй байна.

Хөрсний хөдөлгөөнт кали ($K_2O$) нүхэн жорлонгийн дэргэдээс авсан дээжид 30 мг буюу дунд зэрэг, бусад цэгээс авсан дээжид 10-20 мг хооронд буюу бага зэргийн агууламжтай, сорьцуудад агуулагдах карбонатын хэмжээ 0.1-2.00 хувийн хооронд хэлбэлзэж байгаагаас үзэхэд хөрс сул карбонаттай байна.

Хүснэгт 12. Хүнд металлын шинжилгээ.

| Дээжний нэр | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Ni /Никель/ | Cd /Кадми/ | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| ШТС-ын хөрс | 34.18 | ND | 16.55 | 5.38 | 51.36 | 47.15 |
| Засварын талбай | 23.35 | ND | 14.98 | 6.04 | 61.60 | ND |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | 150 | 3 | 100 | 100 | 300 | 150 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | 1000 | 10 | 500 | 500 | 600 | 400 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | 1800 | 20 | 1200 | 1000 | 1000 | 1500 |
| Элсэнцэр хөрс | 60 | 1 | 50 | 60 | 100 | 60 |

Нийт сорьцуудад агуулагдах хүнд металлын “Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 13. Хөрсний механик бүрэлдэхүүн.

| Дээжний нэр | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Засварын талбай | 22.1 | 46.1 | 9.4 | 1.3 | 15.3 | 5.9 | 22.4 |
| Кемп | 38.4 | 45.0 | 5.0 | 3.9 | 6.7 | 1.0 | 11.6 |
| ШТМ хадгалах агуулах | 28.8 | 41.8 | 10.4 | 3.5 | 6.7 | 8.7 | 18.9 |
| Хогийн цэг | 14.0 | 52.3 | 10.6 | 1.5 | 15.8 | 5.8 | 23.1 |
| 00-ийн хажуу | 24.2 | 53.8 | 6.7 | 3.2 | 9.3 | 2.8 | 15.3 |
| Машин зогсоол | 17.2 | 52.3 | 5.9 | 3.4 | 12.5 | 8.7 | 24.6 |

Хөрсний механик бүрэлдэхүүнээс үзвэл уурхай орчмын хөрс элсэнцэр болон элсэрхэг механик бүрэлдэхүүн давамгайлсан байна.

**Дүгнэлт**

2023 онд төслийн талбайд хийгдсэн хөрсний бохирдлын судалгаагаар хаягдлын овоолгын дэргэдээс авсан дээжид агуулагдах зарим хүнд металлуудын хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан байна, 2024 оны 10-р сард хийсэн хүнд металлын шинжилгээгээр нийт дээж авсан цэгүүдийн хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдол байхгүй байна.

Химийн урвалын хувьд төслийн талбай орчмын хөрс шүлтлэг, хөрсний үржил шимт чанараар ядмаг, физик шинж чанарын хувьд элсэнцэр хөрс байна.

Цаашид хөрсний мониторинг судалгааны дата бааз цуглуулах үүднээс тогтсон хяналтын цэгүүд байгуулна.

**2. Усны шинжилгээний үр дүн.**

Харьцуулсан стандарт, үзүүлэлтүүд:

- Хүрээлэн буй орчин. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандарт,
- Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS 4586:1998 стандарт
- Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал усны ерөнхий шаардлага стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4943:2015,
- Усны хатуулаг.

| | **1.50 мг-экв/л-ээс бага** | **1.50-3.00 мг-экв/л** | **3.01-5.00 мг-экв/л** | **5.01-7.00 мг-экв/л** | **7.01-9.00 мг-экв/л** | **9.01 мг-экв/л-ээс их** |
|---|---|---|---|---|---|---|
| **Хатуулгын зэрэг** | Маш зөөлөн | Зөөлөн | Зөөлөвтөр | Хатуувтар | Хатуу | Маш хатуу |

— Усны эрдэсжилт. А.М.Овчинниковын ангиллыг баримтлав.

| | 200 мг/л-аас бага | 210-500 мг/л | 510-1000 мг/л | 1100-3000 мг-экв/л | 3000-7000 мг-экв/л | 7100 мг-экв/л-ээс их |
|---|---|---|---|---|---|---|
| **Эрдэсжилт** | Нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй | Цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй | Цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй | Давстайвтар буюу их эрдэсжилттэй | Давстай буюу шорвогдуу | Их давстай буюу шорвог |

**2024.04-р сар**

2024 оны 04-р сард “Хөөтийн булаг”-ийн ус болон уурхайн унд ахуйн хэрэглээнд ашиглаж буй шүүлтүүртэй уснаас сорьц авч Дундговь аймгийн УЦУОХШГазраар доорх үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.

Хүснэгт 14. Усны шинжилгээний үр дүн

| Тодорхойлсон үзүүлэлтүүд | Сорьц авсан цэгүүд | | MNS4586:1998 Хүлцэх агууламж мг/л | |
|---|---|---|---|---|
| | Булгийн ус | Ундны ус | | |
| Жинлэгдэх бодис, Ж/Б мг/л | 2.8 | Илрээгүй | - | - |
| Перманганатын исэлдэх чанар, Пич мг/л | 2.6 | Илрээгүй | 10 | |
| Кальцийн ион(Ca2+) мг/л | 123.2 | 1.6 | 100 | |
| Магнийн ион (Mg2)мг/л | 149.6 | 1.6 | 30 | |
| Аммоний ион (NH4) мг/л | 0.19 | 0.07 | 1.5 | |
| Нийт төмөр (Fe) мг/л | 0.31 | 0.02 | 0.3 | |
| Хлорийн ион (Cl) мг/л | 163.1 | 0.7 | 350 | |
| Сульфатын ион ($SO_4^{2-}$)мг/л | 321.1 | 6.5 | 100 | 0.5 |
| Нитритийн ион ($NO_2$) мг/л | 0.002 | 0.001 | 1.0 | |
| Нитратийн ион ($NO_3$)мг/л | 0.59 | 0.16 | 50 | |
| Фосфатын ион ($PO_4^{3-}$)мг/л | 0.019 | Илрээгүй | 3.5 | |
| Фтор ($F^-$) мг/л | 1.35 | Илрээгүй | - | - |
| Хатуулаг мг-экв/л | 18.45 | 0.25 | 7 | |
| Натри Кали (Na+K мг/л) | 351.0 | 7.2 | - | - |
| ЦДЧ | 2860 | 53 | - | - |
| Гидрокарбонат($HCO_3$) мг/л | 1293.6 | 23.2 | - | - |
| Эрдэсжилт мг/л | 2401.6 | 41.6 | - | - |
| Урвалын орчин (pH) | 7.678 | 6.507 | - | - |

**Шинжилгээний үр дүнгээр:**

“Хөөтийн булгийн ус. химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, I төрлийн, чанарын хувьд их эрдэсжилттэй, давстайвтар, маш хатуу ус байна.

Ундны ус. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокабонатын ангийн, натрийн бүлгийн, I төрлийн чанарын хувьд маш зөөлөн, нэн цэнгэг ялимгүй эрдэсжилттэй ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс унд ахуйн усны чанарын стандарт MNS 0900:2018 стандартад заасан хүлцэх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

Эрдэсжилт.




**2024 оны 10-р сар**

Хүснэгт 15. Дээж авсан цэгийн байршил

| *Дээжийн дугаар* | *Байршил* | *Координат* |
|---|---|---|
| *24/5825* | Гүний худгаас | 45°43'41" 107°41'59" |
| *24/5824* | Ундны усны дээж | 45°43'13" 107°41'59" |
| *24/5827* | Шүүрлийн ус | 45°43'13" 107°41'59" |

Хүснэгт 16. Усны шинжилгээний үр дүн

| **Үзүүлэлт** | **Гүний худаг** | **Ундны ус (ундданд ашиглаж буй крантны ус)** | **Шүүрлийн ус** | MNS0900:2018 Стандартад заасан хүлцэх агууламж, мг/л | MNS 4586:1998 Стандартад заасан хүлцэх агууламж, мг/л |
|---|---|---|---|---|---|
| **Анион (мг/л)** | | | | | |
| **$Cl^-$** | 46.09 | 109.90 | 248.15 | **350.0** | **300** |
| **$SO_4^{2-}$** | 100.87 | 183.86 | 184.03 | | **100** |
| **$NO_3^-$** | 1.38 | 0.69 | 0.34 | **50.0** | **9** |
| **$NO_2^-$** | 0.01 | 0.01 | 0.03 | **1.0** | **0.020** |
| **$CO_3^{2-}$** | - | - | 36.00 | | |
| **$HCO_3^-$** | 439.34 | 1281.42 | 1195.99 | | |
| **Катион (мг/л)** | | | | | |
| **$Na^+ + K^+$** | 108.21 | 218.69 | 237.05 | | |
| **$NH_4^+$** | - | - | 0.10 | **1.5** | **0.5** |
| **$Ca^{2+}$** | 30.06 | 104.21 | 112.20 | **100.0** | |
| **$Mg^{2+}$** | 53.50 | 160.51 | 183.62 | **30.0** | |
| **Fe** | 0.30 | 0.20 | 0.30 | | **300** |
| **pH** | 7.91 | 8.34 | 8.56 | | **6.5 - 8.5** |
| **Хатуулгийн хэмжээ (мг-экв/л)** | 5.90 | 18.34 | 20.70 | | **1.5** |
| **Исэлдэх чанар (мг/л)** | 0.80 | 0.80 | 0.64 | | **10** |

**Шинжилгээний үр дүнгээр:**

Шүүрлийн ус. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна.

Ундны ус. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд их эрдэсжилттэй, маш хатуу ус байна. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Шинжилсэн үзүүлэлтүүд Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай харьцуулан үзэхэд /$Ca^{2+}$/ агууламж стандарт хэмжээнээс 4.21-ээр давсан, магнийн агууламж /$Mg^{2+}$/ стандартад заасан хэмжээнээс харьцангуй өндөр агууламжтай байна.

Гүний худгийн ус. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.

**2024 онд цооногуудад хийсэн усны түвшний хэмжилт.**

Уурхайн үйл ажиллагаанаас тухайн бүсийн гүний усны нөөц, чанарт нөлөө үзүүлж байгаа эсэхийг хянах зорилгоор "Хөөтийн хонхор"-2 ордын хайгуулын ажлын үед өрөмдсөн гидрогеологийн судалгааны ажлын H-2, H-2A цооногуудын усны түвшинд 2024 оны 12-р сарын 05-аас 2024 оны 12-р сарын 15 хүртэлх хугацаанд нийт 4 удаа хэмжилт хийсэн.

Цаашид тус цооногууд болон ойр орчмын малчдын гүний худагт усны түвшний хэмжилтийг тогтмол хийж, гүний худгуудаас усны химийн найрлагын шинжилгээний дээж авч ажиллах, үр дүнг орон нутгийн багийн иргэд болон сав газарт танилцуулж байна.

Хүснэгт 17. Цооногийн хэмжилт

| | Хэмжилт 1 | Хэмжилт-2 | Хэмжилт-3 | Хэмжилт-4 |
|---|---|---|---|---|
| **Огноо** | 2024.12.05 | 2024.12.08 | 2024.12.11 | 2024.12.15 |
| **H-2** | 31.19 | 31.22 | 31.25 | 31.28 |
| **H-2A** | 31.1 | 31.13 | 31.16 | 31.21 |

Хэмжилтийн үр дүнгээс үзэхэд хэмжилт хийсэн H-2, H-2A цооногуудын усны түвшин хоногт 1 см-ээр нэмэгдсэн бөгөөд ямар нэг буурсан үзүүлэлт ажиглагдаагүй. Цаашид хэмжилт хийж буй цооногуудыг тоноглож хэмжилтийн ажлыг тогтмол хийвэл тухайн бүсийн гүний усны түвшинд өөрчлөлт орж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой гэж үзэж байна.

**Дүгнэлт.**

2023, 2024 онд хийгдсэн усны сорьцуудын үр дүнг харьцуулж үзэхэд усны чанарт гарсан өөрчлөлт байхгүй, төсөл хэрэгжиж буй талбай орчмын ус чанарын хувьд ерөнхийдөө их эрдэсжилттэй, давстайвтар, маш хатуу, ус байна.

Уурхайн унд ахуйн хэрэглээнд зөөлрүүлэн хэрэглэж буй ус нь чанарын хувьд маш зөөлөн, нэн цэнгэг ялимгүй эрдэсжилттэй ус буюу унд ахуйн хэрэглээнд тохиромжтой ус байна.

2023, 2024 онд уурхайн шүүрлийн уснаас авсан усны дээжид агуулагдах сульфатын ионы агууламж стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлттэй байна.

2024 оны 10-р сард ажилчдын унд ахуйн хэрэглээний уснаас авсан дээжид агуулагдах магни, кальцийн агууламж өндөр байгаа нь ус хатуулаг өндөртэй байгааг

илтгэж байна.







Иймд цаашид уурхайн худагт суурилуулсан ус цэвэршүүлэх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол хянаж байх, ундны усны шинжилгээг ойр ойрхон авч шинжлүүлж ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Мөн цаашид уст цэгүүдийн хяналт-шинжилгээний мэдээллийн дата бааз үүсгэх зорилгоор хяналтын цэгүүдийг тогтоох,

Шинжилгээний үр дүнгүүдэд хяналт тавьж, усанд агуулагдах бичиг элементүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд, бохирдлын эх үүсвэрийг тогтоох, арга хэмжээ авч ажиллах,

Газрын доорх ус бохирдох явцыг хянах, ойр орчмын малчдын гүний худгаас дээж авах,

Усны судалгааны цооногуудад тогтмол хэмжилт хийх зэрэг ажлуудыг төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлнэ.

## 3. Агаарын чанарын шинжилгээний үр дүн.

2024 оны 04, 10-р саруудад Дундговь аймгийн УЦУОХШГазартай хамран агаар дахь нийт тоосны агууламж, агаар бохирдуулагч бодисын агууламжийг тодорхойлсон.

**Хэмжилт хийсэн багаж**. Орчны агаар дахь нийт тоосны хэмжээг 10 мин хугацаанд SidePak™ AM520 Personal Aerosol Monitor багажийн тусламжтайгаар хийж гүйцэтгэв. Энэ багаж нь PM 10, PM 2.5, PM5, PM1 тоосонцрыг тодорхойлох боломжтой хэмжилтийн үр дүнг мг/м3 нэгжээр, хамгийн их утга, хамгийн бага утга, дундаж утга болон 8 цагийн дундаж гэсэн утгыг тодорхойлох хүчин чадалтай байна.

**Харьцуулсан стандарт:** Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт



Хүснэгт 18. Агаарын чанарын шинжилгээний үр дүн

| № | Дээж авсан цэгийн байрлал | $SO_2$ (мг/м³) | | $NO_2$ (мг/м³) | | Нийт тоос (мг/м³) | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4-р сар | 10-р сар | 4-р сар | 10-р сар | 4-р сар | 10-р сар |
| 1. | Карьер | | 0.007 | | 0.034 | | 0.08 |
| 2. | Тээврийн зам | | 0.005 | | 0.039 | | 0.384 |
| 3. | Ажилчдын хотхон | 0.017 | | 0.049 | | 0.016 | 0.162 |
| 4. | Нүүрсний агуулах | 0.032 | | 0.02 | | 0.015 | |
| 5. | Цайны газрын гадна | | | | | 0.028 | |
| 6. | **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/м3** | **0.45** | | **0.2** | | **0.5** | |

**Хэмжилтийн үр дүн.** Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдэд тархсан тоосны хэмжээ болон бохирдуулагч бодисын агууламж нь Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

**Дүгнэлт:**

- “Хөөтийн хонхор”-2 уурхайн үйл ажиллагааны турш замын усалгааг тогтмол хийдэг,
- Техник хоорондын зай баримтлах, хурдны хязгаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээг байрлуулан мөрдөж ажилладаг.

Цаашид агаарын чанарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө төслийн БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлан, БОАудитын тайланд, өмнөх жилийн ОХШХ-ийн хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнгүүд, орон нутгийн саналд суурилан боловсруулна.

2023, 2024 онуудад хийгдсэн шинжилгээ сорьцуудын үр дүнд үндэслэн 2025 оны менежментийн төлөвлөгөөнд дараах ажлуудыг хийхээр тусгав.

- Агаарын чанарын өөрчлөлтийг хянах зорилгоор хяналтын цэгүүд тогтоож тус цэгүүдэд тогтмол хэмжилт хийх шаардлагатай байна. Жилийн эцэст хэмжилт бүрийн утгыг харьцуулж орчны агаарын чанарт гарсан өөрчлөлтийг тодорхойлон дараагийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө.
- Уурхайн дотоод тээврийн замын усалгааг тогтмол хийх

## 2024 онд төслийн үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж

Төслийн байгаль орчны аудитын тайланг 2024 онд “Цэхи консалтинг” ХХК гүйцэтгэсэн. Байгаль орчны аудитын ажлыг нийт 195 үзүүлэлтээр дүгнэхэд 132 үзүүлэлт нийцтэй, 63 үзүүлэлт үл нийцтэй буюу байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшин 68 хувьтай үнэлэгдсэн байна. Нийт үл нийцлийн 63 шалгуураас бага эрсдэлтэй 21, дунд эрсдэлтэй 29, их эрсдэлтэй 13 байна.

Төслийн байгаль орчны АУДИТ-ын тайлантай танилцан, тус тайланд тусгасан зөвлөмжүүдийн дагуу 2025 оны БОМТөлөвөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга

хэмжээг төлөвлөлөө. АУДИТ-ын тайлангийн дүгнэлт зөвлөмжийг төлөвлөгөөний ард хавсаргав.

| № | Байгаль орчны үзүүлэлт | Аудитын шалгуур | Нийцэл | Үл нийцэл | Эрсдэл | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Их | Дунд | Бага |
| **1.** | Агаарын чанар | 20 | 14 | 6 | 0 | 5 | 1 |
| **2.** | Ус ашиглалт | 30 | 16 | 14 | 1 | 7 | 6 |
| **3.** | Газар, хөрс, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалал | 46 | 35 | 11 | 0 | 7 | 4 |
| **4.** | Биологийн олон янз байдал | 20 | 15 | 5 | 0 | 3 | 2 |
| **5.** | Хог хаягдал | 19 | 13 | 6 | 0 | 2 | 4 |
| **6.** | Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, удирдлага зохион байгуулалт | 42 | 31 | 11 | 7 | 2 | 2 |
| **7.** | Галын аюулгүй байдал, гамшиг осол | 18 | 8 | 10 | 5 | 3 | 2 |
| | Нийт | 195 | 132 | 63 | 13 | 29 | 21 |

## 2025 оны БОМТ-ний нийт зардал

2025 оны БОМТ-ний нийт зардалд 44 083 000 [дөчин дөрвөн сая наян гурван мянга]-н төгрөгийг төсөвлөсөн бөгөөд байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө болох тус зардлын 50 % буюу 22,041,500 [хорин хоёр сая дөчин нэгэн мянга таван зуу]-н төгрөгийг төрийн сангийн 100900013406 тоот дансанд тушаасан.

Хүснэгт 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

| № | Байгаль хамгаалах төлөвлөгөө | Зардал, мян.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 14 250.0 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 10 400.0 |
| 3 | Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө | 10 400.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | - |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2 350.0 |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1 700.0 |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 500.0 |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 4 483.0 |
| 8 | Нийт зардал | **44 083.0** |

**4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил**

| *Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл* | *Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө* | *Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ* | *Хэмжих нэгж* | *Тоо ширхэг* | *Нэгжийн зардал, мян.төг* | *Нийт зардал, мян.төг* | *Хэрэгжүүлэх хугацаа давтамж* | *Хариуцах мэргэжилтэн* | *Баримтлах эрхзүйн баримт бичиг* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах** | | | | | | | | | |
| Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулна | Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааг 2025 оны 04-р сараас 10-р сар хүртэл бороо, цастай өдрөөс бусад өдрүүдэд өдөрт нэг удаа компанийн өөрийн эзэмшлийн 20 тн-ийн багтаамжтай зам усалгааны машинаар хийнэ. | Уурхайн ашиглалтын талбайн тоос үүсгэх гадаргуу | $м^2$ | 30 000 | 800.0 | 800.0 | 2025 | Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн | |
| | Агаарын чанарыг хянах дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох (БО-ны АУДИТ-ын тайланд тусгасан зөвлөмж) | Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт хэмжих | мг/м3 | ОХШХ-т тусгасан хяналтын цэгүүдэд | УАЗ | УАЗ | 2025 | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам, уурхайн шалган нэвтрүүлэх цэгээс гараад зүүн урагш 400 м зайд байх эвдрэл үүсэх эрсдэлтэй хэсэгт тогтмол хянлт тавьж зам засаж сайжруулж байх, | Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам | Км | - | 400.0 | 400.0 | 2025 он | Уурхайн дарга, Уурхайн уулын ажлын хэсэг, БО-ны мэргэжилтэн | |
| | Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачиж буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд | Уурхайд ажиллаж буй бүх машин техникүүдэд | - | - | 600.0 | 600.0 | 2025 он | Уурхайн ХАБ хариуцсан мэргэжилтэн, БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шуурхай арга хэмжээ авч байх | | | | | | | | |
| | Уурхайн дотоод тээврийн зам дагуу хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах | Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам | ширхэг | - | 50.0 | 200.0 | 2025 он | Уурхайн ХАБ хариуцсан мэргэжилтэн | |
| | Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах | Уурхайн бүх ажилчдад | Хүний тоогоор | 120 | ХАБЭА-н зардлаар | | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн, Уурхайн эмч | |
| | Нүүрс ачсан бүх тээврийн хэрэгсэл ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах | Тээвэрлэлт хийж буй бүх тээврийн хэрэгслүүдэд | Ширхэг | - | - | ҮАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн, ХАБ хариуцсан мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төслийн үйл ажиллагааны явцад дагаж мөрдөх тоосжилтыг хянах бууруулах тухай дотоод журмыг монгол улсын хууль, стандартад нийцүүлэн, уурхайн үйл ажиллагаа, орчны төлөв байдалтай уялдуулж боловсруулах | Төслийн хүрээнд | - | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| **Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах** | | | | | | | | | |
| | Шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрсийг 20-25 см зузаан тайгаар хуулж овоолгод хадгалах | Төслийн хэмжээнд уулын ажлын төлөвлөгөөнд заасны дагуу | м3 | 2912.89 | ҮАЗ | ҮАЗ | 2025 он Шинээр талбай эвдрэх бүрд | Уурхайн уулын ажлын хэсэг, БО-ны мэргэжилтэн | |
| | Түлш, шатахуун, шатах тослох материалын агуулахад холбогдох дүгнэлт, зөвшөөрлийг | Түлш, ШТМ хадгалах агуулах | ширхэг | 1 | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | ***MNS 4628:2013 Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага*** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | авах, (БО-ны Аудитын тайлангийн зөвлөмж) | | | | | | | | *, Шатахуун түгээх станц, галын аюулгүйн норм* |
| | ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах | Уурхайн засварын талбай ШМТ асгарах, алдагдах эрсдэлтэй хэсгүүд | - | - | 500.0 | 500.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн, (ХАБ хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллана). | |
| | Засварын талбайг ШТМ-аар хөрс бохирдохоос сэргийлэн хатуу хучилттай болгох, мөн засвар хийх талбай, техник зогсох хэсэг, засвараас гарсан хог хаягдлыг | Уурхайн засварын талбайд | м3 | 1400 | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байрлуулах хэсгийг тэмдэгжүүлэх | | | | | | | | |
| | Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах | Уурхайн нийт ажилчид, жолооч, операторуудад | - | - | - | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| | Хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгах | Уурхайд ашиглаж буй нүхэн жорлон | ш | 1 | УАЗ | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| **Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах** | | | | | | | | | |
| | Ил уурхайн дэргэд газрын доорх усны түвшин, чанарын өөрчлөлтийг хянах мониторингийн цооногт тогтмол хэмжилт дээжлэлт хийж байх | Уурхайн ухшийн дэргэд | ш | 1-2 цооног сард 2 удаа | - | 9 500.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулах талаар усны мэргэжлийн байгууллага эсвэл усны нарийн мэргэжилтэнтэй хамтран суурь судалгааны ажлыг хийж, үр дүнг орон нутагт танилцуулна. | Төслийн талбайд | - | - | - | 10 000.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| | Төслийн хэрэгцээнд ашиглаж буй усны зарцуулалтыг хэмжих зорилгоор ашиглаж буй усны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуур тавих | Шүүрлийн ус татах хэсэг болон гүний худагт | Ширхэг | 2 | 100.0 | 200.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шүүрлийн усыг шаардлага хангасан хаягдлын сан байгуулан хуримтлуулах, шинжилгээнд хамруулах | Уурхайн карьерт үүссэн шүүрлийн ус | м3 | - | УАЗ | УАЗ | 2025 он | Уурхайн дарга, Уулын ажлын хэсэг, БО-ны мэргэжилтэн | |
| | Нийтийн ариун цэврийн байгууламжийг MNS5924:2015 стандартад нийцүүлэх | Уурхайд ашиглаж буй ариун цэврийн байгууламж | тн | 25 | УАЗ | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| **Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах** | | | | | | | | | |
| Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устах | Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах | Уурхайн кемпийн гадна | ширхэг | 500 | 1240.0 | 1240.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх | Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах | Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд | ширхэг | 100 боодол өвс | - | 1000.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| | Уурхайн карьер луу мал орохоос сэргийлж тогтмол хяналт тавьж ажиллах | Төслийн үйл ажиллагааны явцад | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн, БО-ны мэргэжилтэн | |
| | Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр нийт ажилчдад сургалт явуулах | Уурхайн нийт ажилчдад | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжитэн | |
| | Амьтны талаар нарийвчилсан судалгаар мэргэжлийн | Төслийн хүрээнд | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагаар хийлгэх | | | | | | | |
| **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал 14 250.0 мян.төг** | | | | | | | | |

**4.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажил**

| *Дүйцүүлэн хамгаалах ажлын зорилт* | *Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө* | *Хэмжих нэгж* | *Тоо ширхэг* | *Нэгжийн зардал* | *Нийт зардал* | *Хэрэгжүүлэх хугацаа давтамж* | *Хариуцах мэргэжилтэн* | *Баримтлах эрхзүйн баримт бичиг* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох; Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох | Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын хөрс цаг уурын судалгаа хийж суулгахад тохиромжтой мод, бут, сөөгийг тодорхойлох төлөвлөгөө гаргах | - | - | 1 000.0 | 1 000.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | - Байгаль орчныг хамгаалах тухай хууль<br>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль<br>- Усны тухай хууль<br>- Амьтны тухай хууль |
| | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тариалах модлог ургамлын төрөл зүйлийг өсгөж үржүүлэх плантац, үржүүлгийн талбай, хүлэмж байгуулах бэлчээрийн талбайг ургамалжуулах хашиж хамгаалах | га | 5 | 4 400.0 | 4 400.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| | “Аргын хад” орон нутгийн тусгай хамгаалалттай газарт зэрлэг ан амьтан ундаалах зорилгоор хөв цөөрөм байгуулах талаар усны | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжлийн байгууллага эсвэл усны нарийн мэргэжилтэнтэй хамтран суурь судалгааны ажлыг хийх. | | | | | | | |
| | Хөөтийн булгийн эхийг хашиж хамгаалсан хашааг булгийн усны ундаргад нөлөө үзүүлэхээргүй байдлаар дахин хашаалах | ширхэг | - | 5 000.0 | 5 000.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| **Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний нийт зардал 10,400.0 мян.төг** | | | | | | | | |

***4.3.* Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Ашиглалтын талбайд одоогоор нөхөн сэргээх орон зай үүсээгүй байгаа тул 2025 онд ашиглалтын талбай дотор техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй болно.

| ***Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*** | ***Хэмжих нэгж*** | ***Тоо ширхэг*** | ***Нэгжийн зардал, мян.төг*** | ***Нийт зардал, мян.төг*** | ***Хэрэгжүүлэх хугацаа давтамж*** | ***Хариуцах мэргэжилтэн*** | ***Баримтлах эрхзүйн баримт бичиг*** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгыг хэлбэршүүлж, салхинд хийсэхээс хамгаалан олон наст ургамлын үрээр ургамалжуулах | м2 | - | | 10 000.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор тухайн бүсэд ургадаг ургамлын төрөл зүйлийн судалгаа хийх, нөхөн сэргээлтийн туршилт судалгааны талбай байгуулах газрыг төлөвлөх | га | - | - | 400.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | “Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2023/ |
| **Нөхөн сэргээлтийн нийт зардал 10,400.0 мян.төг** | | | | | | | |

**4.4. “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажил**

| ***Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*** | ***Хэмжих нэгж*** | ***Тоо ширхэг*** | ***Нэгжийн зардал, мян.төг*** | ***Нийт зардал, мян.төг*** | ***Хэрэгжүүлэх хугацаа давтамж*** | ***Хариуцах мэргэжилтэн*** | ***Баримтлах эрхзүйн баримт бичиг*** |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ажилчдын ажлын байр орчмын тоосжилтыг бууруулах зорилгоор 2025 онд уурхайн кемпийн урд хэсэгт 0.01 га талбайд хайлаас модыг суулгацаар шуудуулан тарина. | Ширхэг | 500 | УАЗ | УАЗ | 2025 оны хавар тарьж намар ургалтыг хувийг тодорхойлно. | Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | “Тэр бум мод” үндэсний хөтөлбөр, |
| Орон нутгаас ирүүлсэн саналын дагуу төсөл хэрэгжих Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт | Ширхэг | 500 | УАЗ | УАЗ | 2025 оны хавар | Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| “Биг могул коул энд энержи” ХХК-ийн нэр дээр мод тарих талбай заалгах, тус талбайд бүс нутгийн байгаль цаг уурын онцлогт тохирсон 500 ш мод тарьж ургалт, арчилгаа, тордолгоог хариуцах ажиллах | | | | | | | |




зураг 1. Уурхайн кемпийн гадна мод тарих талбайн зураг

## 4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн лицензийн талбай дотор одоогийн байдлаар газар дээр ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор, түүх соѐлын дурсгалт зүйл илрээгүй. Цаашид төсөл хэрэгжүүлэх явцад газар доор ямар нэгэн түүх соѐлын дурсгал илэрсэн тохиолдолд тухайн төслийн үйл ажиллагааг түр зогсоож Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу ГТГ, ШУА-ийн Археологийн хүрээлэнд урьдчилан мэдэгдэж, мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах, малтлага судалгааны ажлыг хийлгэж, холбогдох байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна.

## 4.6. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

## 4.7. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

| *Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл* | *Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө* | *Хэмжих нэгж* | *Тоо ширхэг* | *Нэгжийн зардал* | *Нийт зардал* | *Хэрэгжүүлэх хугацаа давтамж* | *Хариуцах мэргэжилтэн* | *Баримтлах эрхзүйн баримт бичиг* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Байгалийн гамшигт үзэгдлээс үүсч болзошгүй осол эрсдэл** | | | | | | | | |
| Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах | Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайн үйл ажиллагааг байгальд ээлтэйгээр зохицуулах | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | Уурхайн дарга | Онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө |
| | Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудын гадаргыг урсцаас хамгаалах ба тэдгээрээс бодис зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу байгуулах | - | - | 500.0 | 500.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай болгон, алдаж асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчихгүй байхаар тохижуулах | - | - | - | 500.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| | Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах | Хүний тоогоор | - | - | 450.0 | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн | Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89 |
| Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй. | Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах, гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц байрлуулах, хуурайшилт ихтэй саруудад гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах | Ширхэг | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн | |
| **Ажлын байрны осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ** | | | | | | | | |
| Ажилчид бэртэх, эрүүл мэнд | Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй | Нийт ажилчдад | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн | Хөдөлмөрийн аюулгүй байдал, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх | ажиллагааны зааварчилгаанд хамруулах | | | | | | | эрүүл ахуйн тухай хууль, MNS 4990:2023, MNS 4969:2000 |
| | Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах | Нийт ажилчдад | - | - | 500.0 | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн | |
| | Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, машины кабин, ажлын байрт байрлуулсан анхны тусламжийн эмийн сангийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж байх | Үйл ажиллагаанд ашиглаж буй машин механизм | Ширхэг | - | 400.0 | 2025 он | Уурхайн эмч | |
| | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх | Нийт ажилчдад | Хүний тоогоор | - | ҮАЗ | 2025 он | Уурхайн эмч | |
| **Осол эрсдлийн арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал 2,350.0 мян.төг** | | | | | | | | |

**4.8. Хог хаягдлын менежмент**

| *Хог хаягдлын төрөл* | *Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө* | *Хэмжих нэгж* | *Тоо ширхэг* | *Нэгжийн зардал* | *Нийт зардал* | *Хэрэгжүүлэх хугацаа давтамж* | *Хариуцах ажилтан* | *Баримтлах эрхзүйн баримт бичиг* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Ажилчдын хэрэглээнээс үүссэн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж дахин боловсруулах боломжтой хог хаягдлын сард үүсэх хэмжээг тодорхойлох | Төслөөс гарах хог хаягдал | кг | - | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжил тэн, уурхайн кемп менежер | Монгол улсын “Хог хаягдлын тухай” хууль, |
| | Ахуйн хэрэглээнээс гарсан хуванцар савыг цуглуулж сум эсвэл аймгийн дахивар авах цэгт тушаах | | | | | | БО-ны мэргэжил тэн | |
| | Хатуу хог хаягдлыг түр хадгалах цэгт цугларуулах цэгийг хатуу хучилттай болгон тохижуулах, хогийн цэгт хуримтлагдсан хогийг гэрээний дагуу сард нэг удаа сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх | - | - | 1,500.0 | 1,500.0 | 2025 он | БО-ны мэргэжил тэн | Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол, Хог хаягдлын тухай хууль, MNS 5924:2015 |
| | Кемпийн гадна орчны болон хогийн цэгийн эргэн тойронд салхинд хийсэж тарсан, ил задгай хаясан хог хаягдлыг тогтмол цэвэрлэх | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | Уурхайн кемп менежер | Хог хаягдлын тухай хууль, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бие засах газар ахуйн бохир усны нөлөөгөөр байгаль орчин бохирдох | Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг бохирын цооногт хуримтлуулж, мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан цооног дүүрэх үед соруулах,<br>Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлэх,<br>Хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонг буулгах | - | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн | Хог хаягдлын тухай хууль, |
| Шатах тослох материалаар хөрс бохирдох | Ашигласан тос тосолгооны материалын хаягдлыг гэрээлэгч компанид улиралд нэг удаа нийлүүлэх, | - | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн | Хог хаягдлын тухай хууль, |
| Хог хаягдлын бүртгэл мэдээлэл хөтлөх | Хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг хөтлөх. Хог хаягдлын бүртгэл, баталгаажуулалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. Хог хаягдалтай холбоотой бүх төрлийн мэдээллийг баримтжуулж, мэдээллийн сан үүсгэж байх. | - | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | Хог хаягдлын тухай хууль, |
| | Хог хаягдлыг ангилан ялгах боломжтой савыг уурхайн шалган нэвтрүүлэх хэсэгт нэмж байршуулах, | ширхэг | - | 200.0 | 200.0 | 2025 он | БО-ны мэргэжилтэн, кемп менежер | Хог хаягдлын тухай хууль, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажилчдын кемпийн гадна хуванцар сав цугларуулах сав нэмж тохижуулах | | | | | | | |
| **Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал 1,700.0 мян.төг** | | | | | | | | |

***4.9.* Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн зардал | Нийт зардал | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Хариуцах мэргэжилтэн | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх төлөвлөгөө** | | | | | | | | | |
| БО,ХАБЭА-тай холбоотой хууль, дүрэм журмын шаардлагыг бүрэн хангаагүйгээс эрх зүйн зөрчил бий болох, эрсдэл үүсэх | Тухайн жилд байгаль орчинтой холбоотой уурхайд байх шаардлагатай бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллах | Байгууллагын хэмжээнд | - | - | ҮАЗ | ҮАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | - Байгаль орчныг хамгаалах тухай хууль<br>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль<br>- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль<br>- Газрын тухай хууль<br>- Усны тухай хууль<br>-Хөдөлмөрийн |
| | 2025 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөө зэргийг | Төслийн хэмжээнд | - | - | 500.0 | 500.0 | 2025 он | ХАБ хариуцсан мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дотооддоо боловсруулан батлах | | | | | | | | аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<br>- “Журам батлах тухай” БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 дугаар |
| | Жил бүр байгаль орчинтой холбогдолтой төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх | Төслийн хэмжээнд | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | БО-ны мэргэжилтэн | |
| | Орчны хаянлт шинжилгээний хөтөлбөрийн дотоод хяналтыг явуулах, дотоод хяналтын тайлан, мэдээг ажилдаа ашиглах, мэргэжлийн албанд дотоодын хяналтын тайлан, мэдээгээ гаргаж өгөх | Төслийн хэмжээнд | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | Дотоод хяналтын ажилтан, БО-ны мэргэжилтэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт ажилчдыг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамруулах | Төслийн хэмжээнд | - | - | УАЗ | УАЗ | 2025 он | | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 18.1.2 |

## ТАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь “Хөөтийн хонхор”-2 нэртэй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор агаар, хөрс, гадаргын болон газрын доорх ус, ургамал, амьтаны нөхцөл байдалд ажиглалт явуулах, хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааны удирдамж болно.

Уг ОХШХ- ийг төлөвлөхдөө төслийн БОННУ-ний нэмэлт тодотголын тайлангийн ОХШХ, 2023, 2024 оны орчны хяналт шинжилгээний хүрээнд цуглуулсан дата, мэдээг үндэслэн шинжилгээ хийх үзүүлэлтүүд, дээж авах байршил, хугацаа, давтамж, хяналт шинжилгээ хийх аргачлал, стандарт зэргийг оруулав.

- 2025 онд хөрс болон агаарын чанарын дээж авах хяналтын цэг байгуулна:

Хүснэгт 20. Хяналтын цэг байгуулах цэгийн солбицол (дээж авах цэгийн байршил сонгохдоо төслийн талбайд 2023, 2024 онуудад хийсэн мониторингийн судалгаанд үндэслэв.)

| № | Дээж авах цэгийн байрлал | Өргөрөг | | | Уртраг | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| | 1. Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүд | | | | | | |
| 1. | Засварын газар | 45 | 43 | 05.1960 | 107 | 42 | 00.0000 |
| 2. | Шимт хөрсний овоолго | 45 | 43 | 23.4840 | 107 | 42 | 15.5880 |
| 3. | Хог хаягдлын цэг | 45 | 42 | 20.5920 | 107 | 42 | 33.5850 |
| 4. | Аюултай хог хаягдлын цэг | 45 | 43 | 03.6120 | 107 | 41 | 58.2000 |
| 5. | ШТС | 45 | 43 | 04.800 | 107 | 42 | 11.1960 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | карьер | 45 | 43 | 44.6040 | 107 | 42 | 07.0920 |
| 7. | Хяналтын хөрс | 45 | 43 | 45.0840 | 107 | 42 | 22.5000 |
| 2. Хүнд металлын шинжилгээ | | | | | | | |
| 8. | ШТС | 45 | 43 | 04.800 | 107 | 42 | 11.1960 |
| 9. | Аюултай хог хаягдлын цэг | 45 | 43 | 03.6120 | 107 | 41 | 58.2000 |
| 10. | Уурын зуух | 45 | 43 | 17.26 | 107 | 42 | 1.75 |
| 3. Агаарын тоосжилт хэмжих цэгүүд | | | | | | | |
| 11. | Ажилчдын хотхон | 45 | 43 | 07.3 | 107 | 42 | 05.3 |
| 11. | Уурхайн карьер дотор | 45 | 42 | 43.5 | 107 | 42 | 02.0 |
| | Карьерийн дээд хэсэгт | 45 | 42 | 44.64 | 107 | 41 | 57.22 |
| 4. | Нүүрсний агуулах | 45 | 43 | 14.1 | 107 | 42 | 10.6 |
| 5. | Засварын газар | 45 | 43 | 5.18 | 107 | 42 | 0.22 |
| 6. | Дотоод тээврийн зам | 45 | 43 | 3.20 | 107 | 42 | 11.63 |
| 7. | Гадаад тээврийн зам | 45 | 42 | 24.86 | 107 | 43 | 5.08 |
| 4. Агаар бохирдуулагч бодисын шинжилгээ | | | | | | | |
| 15. | ШТС | 45 | 43 | 04.800 | 107 | 42 | 11.1960 |
| 16. | Дотоод тээврийн зам | 45 | 43 | 3.20 | 107 | 42 | 11.63 |

| *№* | *Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд* | *Байршил* | *Хугацаа ба давтамж* | *Хяналт шинжилгээний ажлын хэмжээ* | *Нэгжийн өртөг мян.төг* | *Нийт зардал, мян.төг /жил* | *Баримтлах стандарт ба арга, аргачлал* | *Дээд доод хязгаар* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **АГААРЫН ЧАНАР** | | | | | | | | |
| 1 | Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM2.5, PM10 Тоосны уналт | Ил уурхайн салхины чиглэлийн доор Уурхайн тосгон Ажлын байр Карьерын дотор дээд, дунд, доод | Жилд 4 удаа буюу улирал тутам | Тоосжилтын хяналтын явуулах мониторингийн 7 цэгт | 33.0 | 925.0 | MNS 4585:2016 MNS:3384:1982 MNS:4048:1988 | PM2.5-0.05 мг/м3 PM10-0.1мг/м3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэсэг | | | | | | |
| 2 | Бохирдлын цэгэн эх үүсвэр: SOx, NOx, COx | Уурхайн гадаад, дотоод тээврийн замын хажууд | Жилд 4 удаа буюу улирал тутам | Бохирдуулагч хийн хяналт шинжилгээ явуулах мониторингийн 2 цэгт | 50.0 | 100.0 | MNS 4585:20216<br>MNS:3384:1982<br>MNS 4048:1988 | ЗДХ |
| **ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС** | | | | | | | | |
| 1 | Гадаргын болон газрын доорх усны чанар:<br>Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж, | Уурхайн худаг бүрээс Уурхайн шүүрлийн уснаас /1 цэгээс / Булаг<br>-<br>Мониторингийн цооног /шинээр байгуулна/ | Жилд 4 удаа | Нийт 4 цэг дээр дээжлэлт хийж шинжлэх | 43.0 | 688.0 | MNS (ISO) 5667-1:2002<br>MNS (ISO) 5667-1:2004<br>MNS ISO 5667-5:2001<br>MNS 900-2018<br>MNS 6148;2010<br>MNS 4586 : 1998 | ЗДХ |
| 2 | Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ | Унд ахуйн ус | Жилд 4 удаа | Унд ахуйн хэрэглээний ус | 37.5 | 150.0 | MNS 900-2018 | ЗДХ |
| | Газрын доорх усны түвшин, хэмжих | Мониторингийн цооног | Улиралд нэг удаа | Нийт 2 цэг дээр хэмжилт | - | - | Хуваарийн дагуу | |
| **ХӨРСӨН БҮРХЭВЧ** | | | | | | | | |
| 1 | Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүдийг хянах | -Засварын газар<br>-Хог хаягдлын цэг<br>-ШТМ-ын | Жилд 3 удаа Дулааны улиралд авах | Уурхайн бүсийн орчим мониторингийн 7 ш тогтмол цэгт | 25.0 | 525.0 | MNS 5850 : 2019<br>MNS 3298 : 1991 | ЗДХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Агуулах<br>- Шимт хөрсний овоолго,<br>- Ил уурхайн дэргэд,<br>- Нөхөн сэргээлт хийсэн талбай, | | | | | | |
| 2 | Хөрсний бохирдлын хэмжилт (цацраг идэвхт элементүүд, хүнд металлууд, нефть бүтээгдэхүүн, органик Бохирдуулаг) | - Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд<br>-Уурын зуух<br>- Хог хаягдал бохирын цэгийн орчимд | Жилд 3 удаа Дулааны улиралд авах | Уурхайн бүсийн орчим мониторингийн 3 ш тогтмол цэгт | 25.0 | 225.0 | MNS5850 : 2019 | ЗДХ |
| **УРГАМЛАН НӨМРӨГ** | | | | | | | | |
| | Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, ургамлын дундаж өндөр, Газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га | Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд | Жилд 3 удаа ургамал ургалтын хугацаанд | Ургамлын хяналт шинжилгээг мониторингийн 3-5 цэгт | | 600.0 | MNS5850:2019 | ЗДХ |
| **ДУУ ЧИМЭЭ ДОРГИО ЧИЧИРГЭЭ** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Гадаад орчны дуу чимээ | Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд | Жилд нэг удаа | Хяналт шинжилгээ явуулах 2 мониторингийн цэг дээр | | 100.0 | MNS4585:2016 | 60 дБ |
| | Ажлын байрны дуу, чимээ | Ил уурхайн орчимд | Жилд нэг удаа | Шаардлагатай ажлын байруудад | | 100.0 | | 85 дБ |
| **Нийт ОХШХ-ийг хэрэгжүүлэх нийт зардал 4483.0 мян.төг** | | | | | | | | |

## ЗУРГАА. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацаа тов |
|---|---|---|---|---|
| | **1** | **2** | **3** | **4** |
| 1 | Баянжаргалан сумын 2-р багийн иргэд | ИНХ-д танилцуулах | Тухайн жилд хийгдсэн ажил | Тухайн оны 4-р улирал |
| 2 | Дундговь аймгийн Байгаль орчны газар | https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах | Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал | Тухайн оны 11 - р сарын 1 дотор |
| 3 | Төрийн захиргааны төв байгууллага | https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах | | Тухайн оны 12 - р сарын 1 дотор |

2025 онд байгаль орчинтой холбоотой зохион байгуулах нийт сургалтууд:

| № | Сургалтын сэдэв | Зохион байгуулах хугацаа | | | | | | | Хариуцах мэргэжилтэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | IV | V | VI | VII | VIII | IX | X | |
| 1. | Ажлын байрны эрүүл ахуй, тоосноос эрүүл мэндээ хамгаалах тухай | | | | | | | | Уурхайн БО-ны мэргэжилтэн, эмч |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх тухай | | | | | | | | БО-ны мэргэжилтэн |
| 3. | Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, тэдгээрийг хамгаалах | | | | | | | | БО-ны мэргэжилтэн |
| 4. | Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт | | | | | | | | ХАБ хариуцсан мэргэжилтэн |
| 5. | Дахин ашиглах боломжтой хог хаягдал, тэдгээрийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тухай | | | | | | | | БО-ны мэргэжилтэн |

# НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10[1] дүгээр зүйлд "Байгалийн нөөц, баялагийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутамд байгаль орчны аудит хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ" гэсэн заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын баталсан 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А-126 дугаар журам, "Биг могул коул энд энержи" ХХК-тай байгуулсан "Экологийн хариуцлагын гэрээ"-ний дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай "Хөөтийн хонхор-2" нэртэй ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанд Байгаль орчны аудитын ажлыг гүйцэтгэлээ.

Байгаль орчны аудитын ажлыг 2023 оны 11-р сарын 02-ны өдрөөс 2024 оны 01-р сарын 08-ны өдрийн хооронд агаарын чанар, ус ашиглалт, газрын менежмент, хөрс, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалал, биологийн олон янз байдал, хог хаягдал, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, гамшиг осол, галын аюулгүй байдал, удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хууль тогтоомж холбогдох бодлого, хөтөлбөр, дүрэм, журам, стандарт, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг тодорхойлсон. Ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд 2022 онд үйл ажиллагаа явуулаагүй нь үнэн болно гэсэн Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 01-р сарын 02-ны өдрийн 1/10 тоот тодорхойлолттой танилцсан болно. "Хөөтийн хонхор-2" нэртэй нүүрсний ордын ил уурхайг 2019 оны 4-р сарын 01-ний өдөр улсын комист хүлээлгэн өгсөн. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг "Майндата" ХХК-иар гүйцэтгүүлж УУХҮЯ, АМГТГ, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна. БОАЖЯ-ны 2023 оны 06-р сарын 08-ны өдрийн 12/3201 дугаартай Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 9.4, 31.4 дэх заалтын дагуу жил бүрийн БОМТ-г боловсруулж БОАЖЯ-аар батлуулан Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.7, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.5 дахь заалтын дагуу БОМТ-ний биелэлтийг тайлагнаж ажиллах шаардлагатай.

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан Дундговь аймгийн БОАЖГ-тай "Ус ашиглуулах гэрээ" байгуулсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Ойн газар"-тай "Санамж бичиг", Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2-р багийн Засаг даргатай "Хог хаядлын гэрээ", "Элемент" ХХК-тай "Химийн хортой болон аюултай бодисын хаягдал устгах ажил гүйцэтгэх гэрээ"-г тус тус байгуулсан. Дундговь аймгийн УЦУОШТ-тэй байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу мониторингийн хэмжилт, судалгаа хийлгэн ажиллаж байна. MV-020772 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг гүйцэтгүүлж ГЗБГЗЗГ-аар 2021 онд батлуулсан байна.

"Биг могул коул энд энержи" ХХК нь "Хөөтийн хонхор-2" нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанд хийсэн Байгаль орчны аудитын үнэлэмжийн үнэлгээгээр үл нийцэлтэй гарсан заалтуудыг засаж сайжруулах, хэрэгжүүлэх талаар шат дараалалтай арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрөлтэй "Хөөтийн хонхор-2" нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, улмаар бүрэн арилгах, үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

*Агаарын чанарын чиглэлээр*

❖ Агаарын чанарыг хянах дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах, дотоод хяналтын тайлан, мэдээг ажилдаа ашиглах, мэргэжлийн албанд дотоодын хяналтын тайлан, мэдээгээ гаргаж өгөн агаарын тухай хуулийн 9.1.5, 12.4 заалтыг биелүүлэх;

❖ Уурхай, уурын зуух гэх мэт тоосжилт ихтэй орчинд ажиллаж байгаа ажилчдын амьсгалын замыг хамгаалах олон давхар шүүлтүүртэй тоосыг сайн шүүдэг хошуувчаар хангах, байнга хэрэглүүлж хэвшүүлэх;

*Ус ашиглалтын чиглэлээр*

❖ Уурхайн үйл ажиллагаанд карьерын шүүрлийн усыг ашиглах тохиолдолд Усны тухай хуулийн 30.1.4-р заалт болон "Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам"-д заасан шаардлагыг баримталж уурхайн байгууламж зумфны ус шахах шахуурга дээр тоолуур суурилуулж, тоолуурын заалтыг үндэслэн усны төлбөр төлөх;

❖ Уурхайн карьерын зумфэнд шүүрлийн ус хуримтлагдсан бөгөөд түүнийг насосоор татан хоолойгоор дамжуулан ус зайлуулах сувгаар газрын гадаргад гаргаж байна. Иймд шүүрлийн усыг шаардлага хангасан хаягдлын сан байгуулан хуримтлуулж, шинжилгээнд хамруулан шинжилсэн үзүүлэлтүүд нь MNS 900:2005 ундны усны стандарт, MNS 4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан зөвшөөрөгдөх агууламжаас бага гарсан тохиолдолд ногоон байгууламж, замын усалгаанд ашиглах талаар судалгаа хийх;

❖ Усны тухай хуулийн хуулийн 29.2.4-т заасны дагуу хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага, хаях цэг, байршил зэргийг заасан хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авч Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулах;

❖ Нийтийн ариун цэврийн байгууламжийг MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

❖ Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ус ашиглагч нь ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах үүрэгтэй;

❖ Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан сав газрын захиргаанд гаргаж өгөх үүрэгтэй;

❖ ОХШХ-т заагдсан хугацаанд Уурхайн ажилчдын болон нөлөөллийн бүсийн иргэдийн унд ахуйн усны найрлагын макрохимийн шинжилгээг жил бүр хийлгэх, усан дахь хүнд металлын агуулгыг тодорхойлуулах, ундны усанд бактерлогийн шинжилгээг улирал бүр хийж баримтжуулж шинжилгээний үр дүнг ундны усны стандартуудтай харьцуулалт хийж, зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдолд арга хэмжээ авах;

*Газар-хөрс, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын чиглэлээр*

❖ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8, БОНХС-ын 2014.01.06-ны А-05 тушаалыг үндэслэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хийж батлуулах, БОНХС-ын 2014.04.10-ны А-117 тушаалаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсэн үнэлгээ хийх аргачлалыг үндэслэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах;

❖ Түлш шатахуун, шатах тослох материалын агуулахад холбогдох дүгнэлт, зөвшөөрлийг авах шаардлагатай. (MNS 4628 : 2013 Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага, Шатахуун түгээх станц, галын аюулгүйн норм болон бусад холбогдох хууль дүрэм, журам стандартад);

❖ Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолтын ажлыг MNS 5916 : 2008 стандартын дагуу гүйцэтгэх;

❖ Тээврийн хэрэгслийн зогсоол, засвар үйлчилгээ явуулах цэг, ШТС-ын талбайг хатуу хучилттай болгож хөрсөнд шатах тослох материал нэвчихээс сэргийлж ажиллах;

❖ Газрын тухай хуулийн 50.1.2 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 51.5 дахь заалт, Газрын хэвлийг хамгаалах тухай хуулийн 20-р зүйлд заасны дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг цаг тухайд нь хийж гүйцэтгэх;

❖ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал болон MNS 5914:2008 "Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт", MNS 5915:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал", MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт" MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага", MNS 5918:2008, "Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага"-ын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх;

*Биологийн олон янз байдлын чиглэлээр*

❖ Амьтны талаар нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг жил бүрийн БОМТ-нд тусган зардал төлөвлөх;

❖ Амьтны тухай хуулийн 6.1.8 дахь заалтын дагуу амьтны идэш тэжээлийн нөхцлийг сайжруулах биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

❖ Уурхайн карьерруу мал амьтан орохоос сэргийлж тогтмол хяналт тавьж ажиллах;

❖ Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр нийт ажилчдад сургалт явуулах;

*Хог хаягдлын чиглэлээр*

❖ Ахуйн хог хаягдлын цэгийг шинэчлэн байгуулах, нийтийн бие засах газар, ахуйн бохир усны танканд хяналт тавих, MNS 4943:2011, MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

❖ Ахуйн хог хаягдлаас шил, лааз, хуванцар, гялгар уут, мод, төмөр гэх мэт хоёрдогч түүхий эдийг хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаадаг болох;

❖ Хог хаягдлын бүртгэл, энгийн хог хаягдлын талаарх мэдээлэл, улирал, жилийн тайланг хуулинд заасан хугацаанд харьяа сумын Засаг даргад, аюултай хог хаягдлын мэдээлэл, тайланг аймгийн Засаг дарга, мэргэжлийн албанд хүргүүлэх;

❖ "Аюултай хог хаягдлын бүртгэл болон тайлангийн маягт"-ын дагуу хөтлөх, аюултай хаягдлын хоргүйжүүлсэн, хоргүйжүүлээгүй эсэхийг тайлангийн бүртгэлд тэмдэглэх, аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах зориулалтын шаардлага

хангасан талбай, агуулахтай болох, аюултай хог хаягдал болон хаягдлын хайрцаг, савыг байршуулсан талбай дээр таних тэмдэг, нэр, хаягийг ил тод хадаж байршуулж байх, химийн бодисуудын хаягдал, сав, баглаа боодлыг тусгай цэг, агуулахад цуглуулж хадгалж байх;

❖ Нийт ажилчдыг хамруулан хог хаягдлын менежментийн сургалт зохион байгуулах;

❖ Уурын зуухнаас гарсан үнсийг ил задгай хаяхгүй байх, орчинд тархахгүй түр хадгалах цэгт хуримтлуулан зөвшөөрөгдсөн хог хаягдын цэгт зөөвөрлөн хүргэх;

*Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, удирдлага зохион байгуулалтын чиглэлээр*

❖ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.4-т заасны дагуу Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;

❖ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах;

❖ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.5-т заасны дагуу Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;

❖ Эрүүл ахуйн тухай хуулийн 20.1.7-т заасны дагуу Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт автотехникийн засвар хийх, тос, тосолгооны материалыг ил задгай хаяхыг хориглож автотехникийн засвар үйлчилгээний талбайг хатуу хучилттай болгох;

❖ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-т заасны дагуу палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах;

❖ Ажилчдын амрах байранд шаардлага хангасан эмийн сан байрлуулах, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг баримтлах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийх;

❖ Уурхайн дотоод зам талбайд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж нийт ажилчдад байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааг тогтсон хугацаанд явуулж, зааварчилгаа өгч ажиллах;

*Галын аюулгүй байдал, гамшиг ослын чиглэлээр*

❖ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.1-т заасны дагуу гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж батлуулан хэрэгжүүлэх;

❖ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-т заасны дагуу Уурхайн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг батлуулж ажиллах;

❖ Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.1 дэх заалтын дагуу галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилох;

❖ Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10-т заасны дагуу Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах;

❖ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу ажилчдыг гэнэтийн ослын болон холбогдох даатгалд хамруулах;

❖ Шатах тослох материалын хадгалалтын горимыг чанд сахин мөрдөж ажиллах, санамсаргүйгээр асгарсан тохиодлолд саармагжуулах хэрэгслийг шатахуун түгээх газар, засварын талбай зэрэг газар байршуулах;

❖ Гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах, эмнэлэгийн тусламж үзүүлэх сургалтанд ажилчдаа хамруулан мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах;

❖ Галын аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүр төсөвтөө суулгах;

❖ Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6 дахь заалтын дагуу Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллах;

❖ MNS 5566:2005 стандартын дагуу барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, нормыг баримтлан байрлуулах;